



СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛ

СЭТГҮҮЛ

ДУГААР 2023/01

МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН
ЕРӨНХИЙ ХОРОО



www.gec.gov.mn



GEC Mongolia



Монгол Улсын
Сонгуулийн
ерөнхий хороо

СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛ

СЭТГҮҮЛ

ДУГААР 2023/01

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

ЭРХЛЭГЧ

Д.Бат-Эрдэнэ

Мэдээлэл, судалгаа, сургалтын төвийн дарга

ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

З.Бадмаараг

Хорооны хэвлэлийн төлөөлөгч-Референт

ЗӨВЛӨХ

Ж.Амарсанаа

Академич, хууль зүйн шинжлэх ухааны доктор

ГИШҮҮД

П.Алтанчимэг

Мэдээллийн технологийн төвийн ахлах референт

Ш.Сүхбаатар

Хууль зүйн ухааны доктор, судлаач

С.Оюунтуяа

Сонгогчдын боловсрол төв ТББ-ын гүйцэтгэх захирал

Ч.Сайнсанаа

Чимид сангийн тэргүүн

МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО

@Бүтээлийн зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан
тул олшруулахыг хориглоно.



UIN.MN
СУДАЛГААНЫ САН

АГУУЛГА



01 СОНГУУЛИЙН
БОЛОВСРОЛД




02 ЭРХ ЗҮЙН
ОРЧИН



03 СОНГУУЛИЙН
ТҮҮХ




04 ДУГААРЫН
ЗОЧИН



05 СУДАЛГАА



06 СОНГУУЛИЙН
НЭЭЛТТЭЙ
ӨГӨГДӨЛ



07 ХАРИУЦЛАГАТАЙ
СОНГОГЧ
БЭЛТГЭХ
ХӨТӨЛБӨР



08 СОНГУУЛЬ
ДЭЛХИЙ ДАХИНД






СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛД

- Сонгуулийн эрх зүй, түүний эх сурвалж

UIH.MN
СУДАЛГААНЫ САН





СОНГУУЛИЙН ЭРХ ЗҮЙ, ТҮҮНИЙ ЭХ СУРВАЛЖ*

БЯРААГИЙН ЧИМИД

Ардчилсан Үндсэн хуулийн эхийг баригч, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар,
Ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор

Үндсэн ойлголт

Сонгуулийн эрх зүй гэдэг нэг их ойлгомжгүй зүйл биш. Сонгуультайгаа холбоод ойлгож болно. Гэхдээ алсуур нь анхаарч үзүүштэй байдаг. Энгийнээс эхлээд бодъё л доо.

Үндсэн хууль, түүнийг дагуулж гаргасан УИХ-ын сонгуулийн тухай, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай гээд хэд хэдэн хууль байна. Энэ чинь УИХ, Ерөнхийлөгчийн болон ИТХ сонгуультай холбоотой харилцааг хуулиар журамлаж зохицуулдгийн бодит баримт мөн. Тийм шүү.

Сонгууль зарлаж, явуулж, дүгнэхэд насанд хүрсэн бүх иргэн, засаг төрийн болон өөрөө удирдах байгууллага, сонгуулийн хороод, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, зарим талаар аж ахуйн нэгж харилцан хүлээх ямар нэг үүрэг, эрхтэй оролцдог. Үүнийг тэдгээрийн хоорондын сонгуулийн харилцаа гэдэг. Үүнээс дүгнэвэл:

**СОНГУУЛИЙН ХАРИЛЦААГ
ЗОХИЦУУЛЖ БАЙГАА ХУУЛЬ,
ТҮҮНЧЛЭН ЭРХ ЗҮЙН БУСАД
ХЭМ ХЭМЖЭЭНИЙ НИЙЛБЭРИЙГ
СОНГУУЛИЙН ЭРХ ЗҮЙ ГЭНЭ.**

Тэдгээр хэм хэмжээ ба түүнийг ойлгож, хэрэглэж байгаа нийгмийн ухамсар, практикийг бүхэлд нь **СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО** гэж ойлгоно.

Сонгуулийн эрх зүй бол Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүйн нэг дэд салбар юм. Түүний ач холбогдол ямар өндөр болох нь үүнээс ерөнхийдөө мэдэгдэнэ. Түүнчлэн сонгуулийн эрх зүй нь сонгуулийн эрх, сонгох эрх зэрэг ойлголтоос илүү өргөн утга агуулгатай.

Төр улсынхаа улс төрийн харилцааг цэвэршүүлж, засаг төрийн төлөөлөх байгууллагыг ээлжит хугацаагаар нь шинэтгэн сайжруулж, иргэдийн өмнө, тэдний төлөө шударгаар, чадамгай ажиллаж үр дүнтэй үйлчилдэг болгох нөхцөлийг бүрдүүлэхэд сонгуулийн эрх зүйн зохицуулалт тусална. Түүний үр нөлөө нь эрх зүйн хэм хэмжээг сахин биелүүлэгч Та биднээс, хэрэглэгч, байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанаас нэгэн адил шалтгаална. Үүний тул эх сурвалжаа олж мэдээрэй.


Эх сурвалж

Сонгуулийн эрх зүйн эх сурвалж гэдэг өргөн, явцуу хоёр утгатай.

Өргөн хүрээгээр үзвэл:

- сонгуулийн эрх зүйн хэм хэмжээ;
- сонгууль, түүний эрх зүйн ухамсар;
- сонгуулийн хуулийг хэрэглэж ирсэн бодит туршлага (сонгуулийн практик) багтана.

Сонгуулийн эрх зүйн эх сурвалж



Эдгээрээс эрх зүйн "хэм хэмжээ" гэх эх сурвалжийг үзвээс дотор нь **Үндэсний** болон **Олон улсын** гэсэн хоёр их хэсгээс бүрдэнэ. Дотоодын эх сурвалж нь:

- а) хууль тогтоомж;
- б) эрх зүйн бусад актаас бүрдэнэ.

* Б.Чимид. Сонгуульд суралцахуй, УБ, 2008, 41-45 дахь тал.

“Хууль тогтоомж” гэдэг бол дундуур нь таслал тавиад аливааг хамааруулдаг болхи ойлголт биш. Зөвхөн хууль ба УИХ-ын тогтоол (“дүрэм, журам”)-ын нийлбэрийг хэлнэ. Хуулийг үндсэн ба ердийн гэхчилэн хүчин чадлаар ялгаж хэрэглэнэ.

Хууль тогтоомжоос бусдыг **хуулийн дэд акт** гэнэ. Түүнд Засгийн газар, Сонгуулийн ерөнхий хороо зэрэг холбогдох төв байгууллага, мөн орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хэм хэмжээний акт орно. Эдгээр нь хуульд үндэслэсэн, түүний тодорхой заалтыг хэрэгжүүлэхэд шууд чиглэсэн байх боловч анхдагч нь буюу үндэс нь болж чадахгүй.

Үндсэн хууль бол сонгуулийн эрх зүйн анхдагч гол эх сурвалж мөн. Монгол Улсын Үндсэн хуульд энэ тухай тусгай бүлэг байхгүй. Тийм болохоор л зарим нь Үндсэн хуульд сонгуулийн тухай зүйл заалт үгүй мэт тайлбарлахыг оролддог. Үндсэн хууль бол юм бүхний цуглуулга, бүхий л ажлын заавар, арга ажиллагаа (технологи)-ны горим биш. Харин нийгмийн суурь харилцааны зарчмын үндсийг тогтоодог гол хууль юм. Түүний нэг үг томъёолол нь нэг буюу хэд хэдэн зөв хууль болж дэлгэрэн хэрэгждэг жамтай. Энэ нь “сонгууль” гэдэг нэг үгэнд ч хамаатай бөлгөө.

Үндсэн хуульд УИХ, Улсын Ерөнхийлөгч, аймаг, сум, нийслэл, дүүргийн ИТХ-ыг сонгож байгуулах зарчмын үндсийг холбогдох бүлэг зүйлд нь тусган заажээ. Тэдгээр заалтыг сонгуулийн хууль тогтоомжийн зохих актаар, өөрөөр хэлбэл, тус тусад нь зориулсан хуулиар тодруулан зааж хэрэглэдэг. УИХ-ын сонгуульд холбогдохыг нь үзвэл Үндсэн хуульд дараах зүйл заалт бий.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ХОРИН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛЭЭС:

1. Улсын Их Хурал нэг танхимтай, далан зургаан гишүүнтэй байна.

2. Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.

3. Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын хорин таван нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно.

4. Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно.¹

“...журмыг хуулиар тогтооно” гэсэн энэ үндэслэлийг хэрэгжүүлэхийн тулд УИХ-ын сонгуулийн тухай хууль, бусад хууль гарган дагаж мөрддөг.

Мөн Үндсэн хуульд ард түмний засгийн бүрэн эрхт байдал, иргэдийн сонгох, сонгогдох эрхийг тэдний үндсэн эрх болгон заасан байна. Энэ бүхнийг сонгуулийн эрх зүйн Үндсэн хуулийн үндэслэл хэмээн тооцож болно.

Сонгуулийн тухай хууль бол Үндсэн хуулийн дараах эх сурвалж мөн.

Одоо Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Орон нутгийн хурлын сонгуулийн тухай хууль үйлчилж байна. Эдгээр нь **“Үндсэн хуульчилсан” хуульд** хамаарна.

Монгол Улсын сонгуулийн төв байгууллагын тухай хууль, Монгол

¹ Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно. Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх нэг жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно. /Энэ хэсгийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан./

Улсын Их Хурлын тухай хууль, ЭЗНД-ийн нэгж, түүний удирдлагын тухай зэрэг бусад хуульд сонгуулийн шууд холбогдолтой заалтууд байх тул сонгуулийн эрх зүйн эх сурвалж болдгийг анхаарч судлах, хэрэглэх шаардлагатай юм. **Олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, Монгол Улсын олон улсын гэрээ** нь сонгуулийн тухай заалтаараа эх сурвалж болно. Жишээлбэл, Олон улсын эрх зүйн зарчим болох 1948 оны “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”-д (ХЭТТ) **“Ард түмний хүсэл зориг бол засгийн эрх мэдлийн үндэс байх ёстой.** Энэ хүсэл зориг нь сонгуулийн бүх нийтийн, тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хураах буюу саналаа чөлөөтэй гаргах явдлыг хангахуйц өөр адил чанартай хэлбэрийг ашиглах замаар явуулж байвал зохих тогтмол, хуурамч бус сонгуулиар илрэлээ олно.”² гэж тунхагласан байна. Түүнчлэн Монгол Улс 1974 онд нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт (1966 он)-д “Сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хурааж, сонгогчид жинхэнэ хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг баталгаажуулсан, жинхэнэ ёсоор тогтмол явагддаг сонгуульд сонгох буюу сонгогдох эрхтэй” гэжээ.³


“Чөлөөт шударга сонгуулийн шалгуурын тухай” олон улсын парламентын холбооны 1994 оны 154 дүгээр чуулганы тунхаглал зэрэг бусад баримт бичиг⁴ бий. Энэ мэт олон улсын гэрээ бичгийг Монгол Улс Үндсэн хуульдаа харшлахааргүй бол дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил баримтална.

² Монгол Улсын Олон улсын гэрээ. (Эмхтгэл IV боть). 2005 он. 7 дахь тал

³ Мөн тэнд. 10 дахь тал

⁴ А.Н.Головистокова, Л.Ю.Гуриджина “Права человека”. Москва ЭКСМО education. М.2006; с.446



02


ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- Сонгогчдын нэрийн жагсаалтын хяналт, ил тод байдал

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТЫН ХЯНАЛТ, ИЛ ТОД БАЙДАЛ



АРГА ЗҮЙ

Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах ажиллагааны ил тод, хөндлөнгийн хяналттай байдлыг нэмэгдүүлэх, сонгогчдын ирц, оролцоог идэвхжүүлэх арга замыг тодорхойлох, УИХ-ын сонгуулийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн санал бэлтгэж, хүргүүлэх зорилгоор Сонгуулийн ерөнхий хорооны Мэдээлэл, судалгаа, сургалтын төв, Нээлттэй нийгэм форум, Шударга сонгуулийн иргэний нийгмийн сүлжээ, МИДАС ТББ хамтран 2022 оны 12 дугаар сард Сонгуулийн ерөнхий хороо, Тагнуулын ерөнхий газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл тэргүүтэй төрийн байгууллагуудын мэргэжилтэн, судлаачид, иргэний нийгмийн төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэг өрнүүлсэн юм. Хэлэлцүүлгийн мэдээллийг уншигч танаа тоймлон хүргэж байна.

ЕРӨНХИЙ ТОЙМ

Монгол Улс ардчилалд шилжсэн цагаас хойш төрийн эрх барих дээд байгууллага Улсын Их Хурлыг бүх нийтийн чөлөөт сонгуулиар найман удаа сонгон бүрдүүлжээ. Үүнээс 2008 оны сонгуулийн үр дүнг эсэргүүцсэн үймээн нь манай ардчиллын түүхэнд гашуун сургамж болж үлдсэн билээ. Уг сонгуульд хяналт тавьж, ажиглагчаар ажилласан иргэний нийгмийн байгууллагуудын тайлан, бусад эх сурвалжид дурдсанаар бол сонгогчдын нэрийн жагсаалтад сонгогч давхардаж бүртгэгдсэн¹, сонгогчдын шилжилт


¹ Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээ. 2008. УИХ-ын сонгуулийн 22-р тойргийн сонгогчдын нэрийн жагсаалтад хийсэн аудитын дүн, <https://www.sanal.mn/story/182/2008-06-26>

хөдөлгөөн ихээр хийгдсэн, нэг сонгогч давхар санал өгөх оролдлого гарсан, саналыг гараар тоолох явцад зөрчлүүд илэрсэн нь сонгуулийн үр дүн итгэх олон нийтийн итгэлийг сулруулж, улмаар дээрх нөхцөл байдал үүсэхэд нөлөөлсөн хэмээн тайлбарласан байдаг. Энэ сонгуулиас сургамж авч дээрх алдааг дахин давтахгүйн тулд сонгуулийн үйл явцыг автоматжуулах эрх зүйн орчныг бүрдүүлж 2012 оны УИХ-ын сонгуулиас хойш хэрэгжүүлж ирлээ.

Гэвч санал тоолох автомат төхөөрөмж болон сонгогчдыг таних автомат систем, сонгогчдын нэрийн жагсаалтад үл итгэх байдал ажиглагдсаар байна. Ялангуяа, сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой санал, гомдол 2016 оны УИХ-ын сонгуулиас хойш нэлээд гарах болсон. Тухайлбал, 2016 оны УИХ-ын сонгуулийн үеэр “Сонгогчдын боловсрол төв” ТББ-аас сонгогчдод зөвлөгөө өгөх лавлах утсанд ирсэн гомдол, саналын 45 хувь нь сонгогчийн хаягт илүү нэр бүртгэгдсэн тухай, 22 хувь нь дутуу бүртгэгдсэн тухай, Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн үед 24 хувь нь мөн ийм дуудлага, 50 орчим хувь нь сонгогчийн бүртгэлийн хуудастай холбоотой байсан талаар тус байгууллагаас мэдээлж байв.²

Сонгуулийн үйл явцад итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэхэд сонгуулийн үйл явц ил тод, бүх талууд хяналт тавих боломжтой байх нь туйлаас чухал юм. Үүнд бие даасан иргэний нийгмийн байгууллагуудын хяналт чухал бөгөөд МИДАС ТББ сүүлийн хэд хэдэн сонгуульд мониторинг хийснээ хэлэлцүүлэгт танилцуулав.

² “Сонгогчдын боловсрол төв” ТББ-ын мэдээлэл



НЭГ. СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТТАЙ ХОЛБООТОЙ ГАРДАГ ТҮГЭЭМЭЛ АСУУДЛУУД

УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 21-р зүйлийн 21.1 дэх хэсэгт “Сонгогчдын нэрийн жагсаалтыг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд үндэслэн үйлдэх бөгөөд түүнийг нягтлан шалгах, давхардлыг арилгах, сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй сонгуулийн эрх бүхий иргэнийг бүртгэх, эдгээртэй холбоотой гомдлыг шийдвэрлэх ажлыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангана” гэж заасан. 2020 оны УИХ-ын сонгуулийн тухай хууль (УИХСТх)-тай харьцуулахад 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль (ЕСТх)-д сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой зарим дэвшилттэй зохицуулалт туссан ба мөн цаашид сайжруулах шаардлагатай өөрчлөлт байгаа талаар танилцуулбал:

1. УИХСТх-д сонгогч нэрийн жагсаалтаас зөвхөн өөрийн мэдээллийг үзэж хянах боломжтой байсныг өөрчилж мөн хаягт бүртгэлтэй бусад сонгогчийн мэдээллийг шалгах боломжийг ЕСТх-д тусгасан:
 - 23.1. Сонгогч сонгогчдын нэрийн жагсаалт дахь өөрийн болон өөрийн байнга оршин суугаа хаягийн бүртгэлд бүртгэгдсэн нийт сонгогчийн мэдээлэлтэй танилцах эрхтэй бөгөөд сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй,

эсхүл буруу асуудлаар өөрийн болон өөрийн гэр бүлийн гишүүний нэрийн өмнөөс гомдлоо итгэмжлэгдсэн ажилтан, эсхүл улсын бүртгэлийн холбогдох байгууллагад санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө бичгээр гаргана.

- 23.5.Ажиглагч сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулах талаар энэ хуульд заасан хугацаа дууссанаас хойш сонгогчдын нэрийн жагсаалт болон түүнд оруулсан өөрчлөлттэй танилцах эрхтэй.
- 23.6.Ажиглагч энэ хуулийн 23.5-д заасны дагуу сонгогчдын нэрийн жагсаалттай танилцахдаа зураг авах, бичлэг хийх зэргээр сонгогчдын нэрийн жагсаалтыг хувилж, олшруулахыг хориглоно.



- Албан ёсны эх сурвалжийн мэдээлэлд дурдсанаар сонгогчийн нэрийн жагсаалттай холбоотой дээрх өөрчлөлт хуульд туссанаар 2021 оны тавдугаар сарын 12-ны байдлаар 325 мянга орчим цахим хандалт үүсч, 1650 иргэн гомдол гаргажээ. Тэгэхээр энэ нь сонгогчдын нэрийн жагсаалтад иргэдийн хяналтыг сайжруулсан дэвшилттэй өөрчлөлт болох нь харагдаж байна. Гэвч цаашид сайжруулах зүйл байгаа бөгөөд үүнд тухайлбал:
 - Сонгогчдын нэрийн жагсаалтын цахим мэдээллийн санг хэрэглэгчдэд ээлтэй болгох:
 - Сонгогчийн нэрийн хайлтаар Улаанбаатар хот эхэнд гарч ирэхээр тохируулах;
 - "Робот биш" эсэхийг шалгах тохиргоог монгол хэлээр бичих хувилбартай болгох (Сонгогчид англи бичвэрийг ойлгохгүй байх тохиолдол цөөнгүй.)
 - Мэдээллийг баталгаажуулах хэсгийг сайжруулах:
 - Мэдээлэл зөв болохыг сонгогч баталгаажуулсны дараа "баталгаажсан" гэдэг мэдэгдэл гардаг болгож тохируулах;
 - Зөрүүтэй мэдээллийг сануулах тохиргоо үүсгэх (Тухайн хаягт оршин суудаггүй иргэнийг тэмдэглэсэн зэрэг алдааг мэдэгддэг болгох);
 - Байнга оршин суух хаягтай хүмүүст "Түр хасав" төлөв харагддаг байхаар тохируулах.
2. Санал авах байранд сонгогчийн бүртгэлийн төхөөрөмжийг ашиглахтай холбоотой заалтуудыг 2020 оны УИХ-ын сонгуулиас сургамж авч ЕСТх –д дараах байдлаар тусгасан нь хяналт, ил тод байдлыг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой юм. Үүнд:
- Сонгогчийн бүртгэлийн төхөөрөмжийг ашиглах явцад сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой аливаа маргаан гарсан нөхцөлд цаасан баримтад тулгуурлан нягтлах нөхцөл бүрдсэн.
 - 60.7. Сонгогчийн бүртгэлийн төхөөрөмж ажиллахгүй, эсхүл ажиллах боломжгүй болсон бол тухайн сонгогчийн иргэний үнэмлэхийн мэдээллийг сонгогчдын нэрийн жагсаалттай тулган шалгаж, тэмдэглэл үйлдэх бөгөөд уг тэмдэглэлийг үндэслэн тухайн сонгогчид саналын хуудас олгоно. Энэ тохиолдолд иргэний бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтан **сонгогчийн тухайн цаг үеийн гэрэл зургийг авч, овог, нэр, регистрийн дугаар болон бүртгэлийн хуудас олгосон цаг, минутыг** тэмдэглэсэн цаасан архив үүсгэж хадгална.
 - 60.8. Гарын хурууны хээгээр нь сонгогчийг таних боломжгүй бол сонгогчийн иргэний үнэмлэхийн

мэдээллийг сонгогчдын нэрийн жагсаалттай тулган шалгаж сонгогчийн бүртгэлийн хуудас олгох бөгөөд энэ хуулийн 60.7-д заасны дагуу цахим болон цаасан архив үүсгэж хадгална.

- 62.5. Сонгогч саналаа тэмдэглэсэн саналын хуудсаа санал тоолох төхөөрөмж /саналын хайрцаг/-д хийсний дараа **тухайн сонгогч саналаа өгснийг илэрхийлэх тэмдэглэгээг** Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан зааврын дагуу хийнэ.

3. Санал хураах байр тус бүрд **хяналтын камер** ажиллуулж хянах боломж олгосон.

<https://turnout.gec.gov.mn>



4. Бусад өөрчлөлт

- Бүртгэлийн **программын эх кодоод орсон өөрчлөлтүүдийг** СЕХ-ны МТТ-ийн төв Тагнуулын ерөнхий газар, нам эвсэл болон ТББ-ын төлөөлөгчдөд нээлттэй танилцуулсан;



- Нэгдсэн баазад **регистрийн дугаарын давхардлыг** шалгах хүсэлтийн команд бичиж шалгасан;
- Ирцийг **QR кодоор дэлгэцээс** уншуулах боломжтой болсон;
- **Насны ангилалд** өөрчлөлт оруулж илүү нарийвчилсан.

Сонгогчдын нэрийн жагсаалт нь сонгуулийн үйл явцыг хуулийн дагуу зохион байгуулахад үндэс болох чухал баримт бичиг тул маргаан зөрчил гарахаас сэргийлж хөндлөнгийн ажиглагч, иргэний нийгмийн зүгээс хяналт тавих боломжоор хангах нь олон улсад нэгэнт тогтсон практик, сайн туршлага юм. Манай улсад энэ нь нэгэнт тогтсон соёл, жишиг бий болжээ. Өмнөх сонгуулиудад сонгогчдын нэрийн жагсаалтын хөндлөнгийн мониторингийг дараах байгууллагууд хийж ирсэн байна. Үүнд:

- Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн сүлжээний гишүүн МИДАС НҮТББ
- Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын (ЕАБХАБ) олон улсын ажиглагчид
- Улс төрийн нам, эвслүүд

ЕАБХАБ-ын олон улсын ажиглагчдын сонгогчдын нэрийн жагсаалтад сонгогчийг бүртгэх болон хяналт тавихтай холбоотой гаргасан дүгнэлт, зөвлөмжийг энд дурдвал:

<https://www.osce.org/odihr/elections/mongolia/>

- Хууль эрх зүйн орчноо Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн зорилго, зорилттой бүрэн нийцүүлэн, **оюуны болон сэтгэцийн бэрхшээлтэй** холбоотой иргэдийн санал өгөх эрхийг хязгаарласан бүх заалтыг хүчингүй болгох хэрэгтэй.

- Хорих ял эдэлж буй бүх хүмүүсийн үйлдсэн **гэмт хэргийн ангиллаас үл хамааран** санал өгөх эрхийг нь хязгаарласан заалтуудыг олон улсын өмнө хүлээсэн үүрэгт нийцүүлэн дахин авч хэлэлцэх.
- Сонгогчийн **түр шилжилт хийх үйл явцыг хялбаршуулж**, санал авах байрнаасаа хол байгаа иргэдийн санал өгөх эрхийг хангах ёстой.
- Хувь хүний мэдээллийн нууцыг хүндэтгэхийн зэрэгцээ сонгогчийн бүртгэлийн явцад итгэх итгэлийг нэмэгдүүлэх үүднээс улс төрийн нам, иргэний ажиглагчдыг сонгогчдын нэрийн жагсаалтад хангалттай хугацаанд **бие даасан шалгалт** хийх боломжоор хангах нь зүйтэй.

Монгол Улсын сонгуулийн насны 122 мянган иргэн гадаадад оршин сууж байгаа (тодорхой, үнэн, зөв тоо гардаггүй.) ч тэд зөвхөн Ерөнхийлөгчийн сонгуульд санал өгөх бололцоотой байдаг.

Гадаад орнуудад сонгуулийг зохион байгуулахад тодорхой хэмжээний хөрөнгө зарцуулдаг ч гадаад улсаас санал өгөхөөр бүртгүүлсэн Монгол иргэдийн тоо хангалтгүй, 7394 сонгогч буюу 6.6 хувь нь оролцохоор бүртгүүлсэн. Тэдгээрээс сонгуульд оролцсон нь 5618 буюу гадаад дахь сонгуулийн насны иргэдийн дөнгөж 4.6% байгаа нь 116 мянга гаруй иргэд сонгох эрхээ эдлээгүй, төсвийн мөнгийг үр ашиг муутай зарцуулж байна. Ирцийг тайлагнахдаа зөвхөн бүртгүүлсэн сонгогчдоос сонгуульд оролцсон сонгогчдын 76% гэж мэдээлдэг нь “амжилттай” зохион байгуулсан мэт хуурмаг сэтгэгдэл төрүүлж байна.

Сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой олон асуудал байгаагаас дараах дөрвөн сэдвийг сонгон зохих шийдлүүдийг хэлэлцсэн болно. Сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой гол сэдвийн нэг нь хаягжилт, иргэний бүртгэл, мэдээлэл боловч тухайн асуудал хариуцсан холбогдох албаны хүмүүс урилгыг хүлээн авсан ч тодорхойгүй шалтгаанаар хэлэлцүүлэгт хүрэлцэн ирээгүйн улмаас уг асуудлыг авч хэлэлцээгүй болно.



ХОЁР: ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД, БОЛОМЖИТ ШИЙДЛҮҮД

СЭДЭВ 1. Сонгогчдын нэрийн жагсаалт дахь “Түр хасав” төлөв бүртгэл

№	Асуудал	Шийдэл
1.	Давхардлыг арилгах	Хөндлөнгийн хяналт бий болгох, мэдээллийн баазад био мэдээллийн давхцыг шалгадаг болох.
2.	“Түр хасав” төлөв ил тод биш.	Мэдэх эрхийг хангах, хяналт тавих боломж нээх үүднээс хянахын тулд нээлттэй болгох.
3.	Итгэл бууруулах	“Түр хасав” төлөвийн тайланг нээлттэй мэдээлэх.
4.	Иргэний бүртгэлтэй зөрчилддөг.	Нэгдсэн дүн мэдээллээ сайжруулж, тулгаж нэгтгэдэг болох.
5.	Сонгогчдын нэрийн жагсаалтыг хуваахдаа офлайн буюу сүлжээнд холбогддоггүй.	Сонгогчдын нэрийн жагсаалтыг онлайн болгох УИХСТХ 20.6.7 Хэсгийн хороонд ажиллаж буй нам, эвсэл нэр дэвшигчдийн ажиглагчдад тухайн хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн нийт сонгогчдын дэлгэрэнгүй тоон мэдээллийг батлагдсан маягтын дагуу нээлттэй өгч болно. Ажиглагч уг мэдээллийг итгэмжлэгдсэн ажилтны ажиллаж буй зөөврийн компьютер дээрх мэдээлэлтэй тоон утгын хувьд таарч байгаа эсэхийг шалгах, нягтлах боломжтой байх.
6.	Сонгуулийн дараа аудит хийгддэггүй.	Сонгуулийн дараа аудит хийдэг болох.
7.	Хаяг тодорхойгүй, бүрэн шийдэгддэггүй.	
8.	“Түр хасав” цаасаар бүртгэдэг.	
9.	Зарим тохиолдолд “түр хасав” төлөвийг сэргээж өгдөггүй.	“Түр хасав” төлөвийг сэргээх үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан тодорхой журам гаргаж зохицуулах.
10.	“Түр хасав” төлөвийг сэргээхдээ янз бүрийн шаардлага тавьж чирэгдүүлдэг. Зарим нь гадаад паспорт нэхдэг, зарим нь өргөдөл нэхдэг.	Яаж сэргээх процедурыг тодорхой энгийн болгох – Жишээ нь: сонгогч өөрийн биеэр ирчихээд байхад гадаад паспорт, хилээр орж ирсэн тамга нэхдэг асуудлыг цэгцлэх.

11.	“Түр хасав” төлөвийг сэргээх тохиолдолд тайлан гардаггүй.	Жагсаалтыг сонгуулиас өмнө, явцад, дараа нь хянах боломжтой болгох.
12.	“Түр хасав” төлөвийг сэргээхдээ гараар шивдэг.	“Түр хасав” төлөвийг сэргээх ажиллагааг ил тод, нээлттэй болгох.
13.	Хил хамгаалах нууцын эрхтэй гээд нэг л хүн сууж тайлан гаргадаг.	Тайланг хянах бололцоо олгох.
14.	Сонгогчдын нэрийн жагсаалтыг нь зөвхөн үзэхийг зөвшөөрдөг, ил тод биш.	Сонгогчдын нэрийн жагсаалтыг байнгын болгох - Удаан хугацаагаар аялах буюу бусад улсад оршин суухаар хилээр гарч буй иргэдийн мэдээлэл - Шүүхийн шийдвэр гэх мэттэй уялдуулан зохих өөрчлөлтүүдийг тогтмол шинэчлэн оруулдаг болох
15.	Гадаадад байгаа иргэдийн мэдээлэл системээс автоматаар гардаггүй.	Бүх процессыг автоматжуулах
16.	Ямар үндэслэлээр “Түр хасав” төлөвт орсон нь ил тод биш.	Нэгдсэн тоог задалж харуулах УБЕГ, СЕХ – нийтэд нээлттэй болгох үүрэг хүлээх
18.	Сонгуулийн бус жилүүдэд ил тод биш.	Сонгуулийн бус жилүүдэд ч мэдээллээ тогтмол шинэчилж ил байршуулдаг болгох.
19.	19.6.1 УДШ-ээр тогтоогдсон эрх зүйн чадамжгүй байдал хэр хугацаанд үргэлжлэх нь тодорхойгүй байна. Хариуцах эзнийг тодорхой болгох.	Сэргээгдэх хугацааг тодорхой заадаг болох, автоматаар сэргээдэг болгох, урьдчилж сэргэсэн тохиолдолд мэдэгдэж бүртгэдэг болох.
20.	Төрийн байгууллагуудын нэгдсэн систем уялдаагүй – УБЕГ, Шүүхийн шийдвэрийн сан, СЕХ гэх мэт.	ХҮР системд оруулах.

СЭДЭВ 2. Түр оршин суугчид, шилжилт хөдөлгөөн (Цэрэг, цагдаа, сонгуулийн ажилтнууд, уурхайн ажилтнууд, оюутнууд...)

№	Асуудал	Шийдэл
1.	Оршин суугаа газраасаа өөр газарт ажиллаж, амьдарч, сурч байгаа иргэд саналаа өгөх механизм хөшүүрэг байхгүй, санал хураах байр хол, биеэр очиход зардал өндөр	Сонгуулийн урьдчилсан санал хураах хүртээмжтэй хэлбэрийг хуульчлах
2.	Саналаа нууцаар бие даан өгөх боломж хангагдахгүй байгаа (уурхай, цэрэг)	Сонгуулийн санал авах хугацаа, хэлбэрийг хүртээмжтэй болгох, Жишээ нь: урьдчилсан санал өгөх байр, хүссэн байршлаасаа саналаа өгөх боломж, цахим санал хураалт зэрэг аргыг нэвтрүүлэх
3.	ЕСТх-ийн 25.1-60 хоног 24.1 боломж олгосон зохицуулалт	
4.	Амралтын үеэр сонгууль зохион байгуулах	Санал авах хугацааг өөрчлөх
5.	Сонгогчид биеэр очиход төвөгтэй байдал үүсгэдэг.	E-Mongolia-гаар, цахимаар бүртгүүлэх боломж /Гадаад улсад байгаа сонгогчид/
6.	Шилжилт хөдөлгөөний хугацаа бага 14 хоног, түүнээс хойш бүртгэхгүй.	Урьдчилж санал өгөхийг сэргээх. Жишээ нь: Тайландад цэрэг, цагдаа гэх мэт сонгуульд ажиллах хүмүүсийн саналыг 14 хоногийн өмнө авдаг.
7.	Сонгуулийн саналын тоонд нөлөөлөх зорилгоор ажилтнуудаа орон нутгийн бүртгэлтэй байлгаж, сонгуулийн үеэр зөөж "царцаа" болгох	Улс төрчдийн хамаарал бүхий аж ахуйн нэгж, байгууллагуудын ажилтнуудын бүртгэлд шалгалт хийж, хянаж торгох
8.	Сонгуулийн хэсгийн хороог засаг захиргааны нэгжээр байгуулдаг.	Газар зүйн байршлаас үл хамаарч, санал өгөх бололцоог бүрдүүлж, бүх тойрогт сонгууль өгч болох тусгай хэсэг зохион байгуулах /Урьдчилан хорих 461-р анги гэх мэт газарт/
9.	Уул уурхай зэрэг үндсэн хаягаасаа өөр газарт ажиллаж, сурч буй хүмүүс санал өгөх боломжгүй.	Эдгээр газарт болон алслагдсан бүс нутгуудад дээрхийн адил тусгай хэсгийн хороо байгуулах тусгай зохицуулалт хийх

СЭДЭВ 3. Гадаад амьдарч байгаа иргэдийн сонгуульд оролцох эрхийн асуудал

№	Асуудал	Шийдэл
1.	Дипломат төлөөлөгчийн газрын байршил хол. (Жишээ нь: 30 улсын 45 төлөөлөгчийн газар)	Бусад орны нутагт улс төрийн ажиллагаа явуулахыг хорьдог тул цахимаар санал өгөх.
2.	Сонгуулийн мэдээлэл дутмаг.	Мэдээлэл хүргэх – Тухайн оронд байгаа иргэдийн сүлжээгээр дамжуулах
3.	Хуулийн хугацаа цаг хугацааны хувьд хэт эрт, нэр дэвшигчид бүрдээгүй байхад бүртгэдэг.	Нэр дэвшигч тодрохтой хугацааг уялдуулах
4.	2 удаа очих нь зардал, мөнгө ихтэй.	Цахимаар бүртгэх, шуудан, цахим шуудан, факсаар бүртгүүлж болдог.
5.	Мэдээллийн аюулгүй байдал	Блок-чэйн технологи ашиглаж, мэдээллийн үнэн зөв байдлыг дээшлүүлэх.
6.	Сонгуулийн тогтолцооноос болоод зөвхөн Ерөнхийлөгчийн сонгуульд саналаа өгдөг.	Нэгдсэн цахим сонгуультай болж УИХ-ын сонгуульд оролцох бололцоог нээх.
7.	Гадаадад байгаа иргэний бүртгэл зөв үү? Гадаадад байгаа иргэдийн тоо зөв гардаггүй.	- Монгол Улсын халамж, нийгмийн даатгалын тогтолцоотой уялдуулан сонгогчдын тоог бодитоор гаргах; - Дипломат төлөөлөгчдийн газар, ГХЯ, Хил хамгаалах газартай хамтран ажиллах.
8.	Сонгууль зохион байгуулах зардал өндөр	Зардлыг бууруулах технологи ашиглах
9.	Элчин сайдын яам хэр ажилладгаас хамаардаг.	Ажлын үзүүлэлтийг дүгнэх шалгууруудыг тодорхой болгож, хамралтыг гол үзүүлэлт болгох
10.	Давхар иргэншилтэй байдал нь сонгуульд оролцох оролцохгүй эргэлзээ төрүүлдэг.	Давхар иргэншлийн асуудлыг нэг тийш нь шийдэх.
11.	Нэрийн жагсаалт тусдаа гардаггүй, бүртгүүлж амждаггүй.	- Цахимаар бүртгэх - Гадаад харилцааны яаманд нэгдсэн сан үүсгэх
12.	Цөөн хүн санал өгдөг. Ажлын бололцоо, өөр хот руу явах зэргээс шалтгаалдаг.	Санал өгөх олон хувилбар санал болгох - Шуудангаар - Цахимаар

13.	Сонгогчдын боловсрол дутмаг.	Урьдчилсан санал хураалт авах.
14.	Судалгаа дутмаг	Цахим сонгууль
15.	Зохион байгуулах хугацаа хэт эрт	Ээлтэй хувилбарууд
16.	Сонгуулийн тогтолцооноос болоод гадаад байгаа иргэд оролцох боломж муу.	Тогтолцоог өөрчлөх

СЭДЭВ 4. Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах үйл ажиллагааны ил тод байдал

ТЕГ-аас аюулгүй байдлын гэрчилгээ авсан байгууллагууд сонгогчдын нэрийн жагсаалтыг авч болно. Үүнийг улс төрийн намууд авдаг. Харин бие даагчид болон иргэний нийгмийн байгууллагуудад өгдөггүй. Сонгуулийн үеэр иргэний нийгмийн ажиглагчид сонгогчдын нэрийн жагсаалттай танилцах боломжтой гэж хуульчилсан ч хяналт, мониторинг хийхэд байнга бэрхшээл учирдаг.

2022 оны 05-р сараас мөрдөж эхэлсэн Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуульд зааснаар дор тодорхойлсон "хүний хувийн мэдээлэл"-ийг хуульд заасан үндэслэлээр болон мэдээллийн эзний зөвшөөрлөөр цуглуулж, боловсруулж, ашиглаж¹ болно. Үүнд:

- Хүний эмзэг мэдээлэл (хүний үндэс, угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, эрүүл мэнд, захидал харилцаа, генетик болон биометрик мэдээлэл, тоон гарын үсгийн хувийн түлхүүр, ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, бэлгийн харьцааны талаарх мэдээлэл)
- хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр
- төрсөн он, сар, өдөр, төрсөн газар
- оршин суугаа газрын хаяг, байршил
- иргэний бүртгэлийн дугаар
- хөрөнгө, боловсрол, гишүүнчлэл
- цахим тодорхойлогч (хүнийг цахим орчинд тодорхойлох мэдээллийн системийн нэвтрэх нэр, цахим шуудан, нийгмийн сүлжээ, харилцаа холбооны утастай болон утасгүй технологийн

хаяг, бусад төрлийн төхөөрөмж, мэдээллийн систем дэх мэдээлэл)

- хүнийг шууд болон шууд бусаар тодорхойлох, эсхүл тодорхойлох боломжтой бусад мэдээлэл.

Дээрхээс сонгогчдын нэрийн жагсаалтад тулгалт хийж, хяналт тавихад зайлшгүй шаардлагатай мэдээлэл нь:

- хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр
- төрсөн он, сар, өдөр, төрсөн газар
- оршин суугаа газрын хаяг, байршил

Сонгогчдын нэрийн жагсаалтын үнэн зөв байдалд иргэдийн итгэл сул байгаа нөхцөлд маргаан үүсэхээс сэргийлж, талуудад хянах боломж олгох нь чухал бөгөөд ЕАБХАБ-ын олон улсын ажиглагчдын зөвлөмжийн дагуу дээрх хуультай нийцүүлсэн өөрчлөлтийг сонгуулийн хууль тогтоомжид тодорхой тусгах шаардлагатай юм.

№	Асуудал	Шийдэл
1.	Цаасан суурьтай бүртгэл	Бүртгэлийг бүрэн цахимжуулах
2.	Иргэний нийгмийн хяналт явцуу хүрээнд ажиглалт хийхээр хуульчлагдсан.	Иргэний нийгмийн хяналтыг зарчим болгож сэргээх
3.	СЕХ-нд бүртгүүлээд байхад хэсэг дээр давхар бүртгүүлэх хэрэгтэй болдог.	Ажиглагчдыг хэсгийн хороодод давхар бүртгэхийг болих
4.	Нэрийн жагсаалт тусдаа хийдэг, бүтэцгүй.	Жагсаалтыг иргэний нийгмийн байгууллагад өгөх боломжийг бүрдүүлэх
5.	Нэрийн жагсаалт эцэслэгдээгүй үед үндсэн зорилгоо хэрэгжүүлдэггүй.	- Хуваах процесст иргэний нийгмийн байгууллагуудад боломж олгох; - Иргэний нийгмийн байгууллагууд албаны нууцтай танилцах аюулгүй байдлын гэрчилгээ авах; - Бааз дээр шалгах боломж олгох.
6.	Сонгуулийн дараа хяналтын асуудал төвөгтэй.	Тухайн сонгогчийн мэдээллийг ямар байгууллага хадгалах, хянах талаар тодорхой үүрэгжүүлэх.

¹ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 4.1.6."мэдээлэл цуглуулах" гэж мэдээллийг олж авах, бүрдүүлэх, бүртгэх үйл ажиллагааг ойлгоно. 4.1.5."мэдээлэл боловсруулах" гэж мэдээллийг ангилах, хадгалах, дүн шинжилгээ хийх, өөрчлөх, устгах, сэргээх үйл ажиллагаа, тэдгээрийн нийлбэрийг, 4.1.4."мэдээлэл ашиглах" гэж мэдээллийг цуглуулах, боловсруулахаас бусад хэлбэрээр үйл ажиллагаандаа хэрэглэх, дамжуулах болон мэдээлэлтэй танилцахыг хэлнэ.

ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ




- УИХ-ын сонгуулийн тухай хуулийг шинэчлэхэд Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд туссан сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой дэвшилтэт өөрчлөлтийг тусгах;
- Сонгогчдын нэрийн жагсаалтад хөндлөнгийн хяналт бий болгох; мэдээллийн баазад био мэдээллийн давхацлыг шалгадаг болох;
- “Түр хасав” төлөвийн мэдээг нэгтгэж, тайланг нээлттэй болгох;
- Сонгогчдын нэрийн жагсаалтыг онлайн болгож, иргэд орон зайд хязгаарлагдахгүй санал өгөх техникийн бололцоог судалж, орчинг бүрдүүлэх;
- “Түр хасав” төлөвийг сэргээх үйл ажиллагааг хялбар, нээлттэй, ил тод болгох, хүнд суртал, шаардах бичиг баримтыг цөөлөх;
- “Түр хасав” төлөвийг сэргээх үйл ажиллагааг тодорхой журам гаргаж зохицуулах;
- Жагсаалтыг сонгуулийн өдрөөс өмнө, явцад, дараа нь хянах боломжтой болгох;
- Сонгогчдын нэрийн жагсаалтыг байнгын ажиллагаатай буюу иргэний бүртгэл мэдээлэлд орох өөрчлөлттэй уялдаатай болон иргэдийн өөрсдийн хяналт, мэдээлэлд үндэслэн байнга шинэчлэгддэг болгох;
- Шилжилт, хөдөлгөөнийг зохицуулж, сонгогчдын хамрагдалтыг нэмэгдүүлэх үүднээс хүссэн байршлаасаа саналаа өгөх боломжийг бүх тойрогт санал өгч болох тусгай хэсэг байгуулах, цахим санал хураалт, урьдчилсан санал хураалт зохион байгуулах;
- E-Mongolia-гаар цахимаар бүртгүүлэх боломжийг судлах;
- Улс төрчдийн хамаарал бүхий аж ахуйн нэгж, байгууллагуудын ажилтнуудын бүртгэлийг хянах замаар “бүртгэлтэй царцааны нүүдлээс” сэргийлэх;

- Гадаадад байгаа иргэдийн сонгогчоор бүртгүүлэх үйл ажиллагааг ойлгомжтой, хялбар болгож цахимаар санал хураах;
- УИХ-ын сонгуульд гадаадад байгаа сонгогч цахимаар оролцож, санал өгөх техникийн бололцоог судалж нээх;
- Гадаад Харилцааны яам, Дипломат төлөөлөгчдийн газар, Хил хамгаалах ерөнхий газар хамтран Монгол Улсын халамж, нийгмийн даатгалын тогтолцоотой уялдуулан гадаадад байгаа сонгогчдын тоог бодитоор гаргах;
- Иргэний нийгмийн хяналтыг зарчим болгож сэргээх, хяналт хийх байгууллагын бүртгэлийг хялбаршуулахыг зөвлөж байна.

Эх сурвалжууд:

- МИДАС ТББ, Монгол Улсын Их Хурлын сонгууль 2020: Сонгогчдын нэрийн жагсаалтад хийсэн мониторингийн тайлан
- **ЕАБХАБ-ын ажиглагчдын сонгогчдын нэрийн жагсаалтад хийсэн дүгнэлт** <https://www.osce.org/odihr/elections/mongolia/>
- Д.Энхцэцэг, Нээлттэй Нийгэм Форум, Засаглалын хөтөлбөрийн менежер, Шударга сонгууль: Сонгуулийн зохион байгуулалтын зарим асуудал, ННФ, Бодлогын асуудал, №01.
- Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээ. 2008. УИХ-ын сонгуулийн 22-р тойргийн сонгогчдын нэрийн жагсаалтад хийсэн аудитын дүн, www.sanal.mn/story/182/2008-06-26



03

СОНГУУЛИЙН ТҮҮХ

- “Ардчилсан” Үндсэн хуулийг баталж,
Монгол Улсад сонгуулийн төв
байгууллагын эрх зүйн үндэс тавигдав
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн
сонгууль-1993

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

19

“АРДЧИЛСАН” ҮНДСЭН ХУУЛЬ БАТЛАГДАЖ, МОНГОЛ УЛСАД СОНГУУЛИЙН ТӨВ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ЗҮЙН ҮНДЭС ТАВИГДАВ

Магистр З.БАДМААРАГ

Сонгуулийн ерөнхий хорооны хэвлэлийн төлөөлөгч-Референт

Үндсэн хуулийн төслийн хэлэлцүүлэг 1991 оны сүүлчээс эхлэн 76 хоног үргэлжилж, 430 депутат оюун бодлоо мэтгэлцэн уралдуулж, улс төрийн зөвшилцлийг хангах, депутатуудын бүлгүүдийн байр суурийг нэгтгэн нэг мөр ойлголтод хүрэх ээдрээ, төвөгтэй замыг туулсны эцэст “Ардчилсан”, шинэ Үндсэн хуулиа 1992 оны нэгдүгээр сарын 13-ны өдөр баталсан юм. Монгол Улсад ардчилсан ёс, хүний эрх, улс төр, эдийн засаг, оюун санааны эрх чөлөө, нийгэм-төрийн байгууллын цоо шинэ тогтолцоог шинэ Үндсэн хуулиараа тунхаглан зарлаж, Шинэ

Үндсэн хуулиа баталснаар Монголд нийгмийн шинэ байгуулал төлөвшин тогтох хууль, эрх зүйн суурь, баталгаа бүрджээ.

Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хууль, Ерөнхийлөгчийн сонгуулийн хууль, орон нутгийн ИТХ-ын сонгуулийн хууль тус тусдаа төрөлжсөн байдлаар батлагджээ.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг анх 1992 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр баталсан Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар зохицуулсан нь Улсын Их Хурлын

сонгуулийн харилцааны эрх зүйн үндэс болжээ.

Ийнхүү 1992 онд батлагдсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль нь сонгуулийн үндсэн зарчим, иргэний сонгох, сонгогдох эрхийг хангах, сонгууль эрхлэн явуулах байгууллагын статусыг тодорхойлж, сонгуульд оролцогч нам, эвсэл, бие даагчдын сонгуульд оролцох оролцоо, эрх үүрэг, сонгогчийн санал авах, тоолох, дүн гаргах зэрэг сонгуулийн үйл ажиллагааг бүхэлд нь зохицуулсан хамгийн анхны, суурь хууль байв.



Энэ хуульд Улсын Их Хурлын гишүүнийг нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, сонгох сонгуулийн үндсэн зарчмыг тодорхойлж өгчээ.

Уг тогтоолын 2 дугаар заалтаар 4 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн бүрэн эрхээ хэрэгжүүлэхийг Сонгуулийн Ерөнхий Хороонд зөвшөөрсөн байна. Ийнхүү Монгол

Улсын Их Хурлын дэргэд Сонгуулийн Ерөнхий Хороо хэмээх цоо шинэ байгууллага үүдээ нээж, өрхөө татан их түүхийн замналаа эхлүүлсэн юм.

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООГ БАЙГУУЛАВ

Байнгын ажиллагаатай Сонгуулийн Ерөнхий Хороог байгуулах эрх зүйн зохицуулалтыг тусгасан Монгол Улсын Их Хурлын тухай хууль дөрөвдүгээр сарын 8-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж, сонгууль явуулах цаг хугацаа давчуу тулсан байв. Сонгуулийн төв байгууллагыг шинээр байгуулах, бүтэц, бүрэлдэхүүнийг 1992 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Бага Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Д.Лүндээжанцан танилцуулж, Хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд нийт 17 хүний бүрэлдэхүүнтэй байхаар төлөвлөн санал оруулжээ.

Улсын Бага Хурлын гишүүд Сонгуулийн Ерөнхий Хорооны бүрэлдэхүүнд бүх нам, Парламентад суудалтай намын төлөөллийг оруулах асуудлыг олон удаа санал хураасны эцэст Улсын Бага Хурлын нарийн бичгийн дарга Б.Чимидийн саналын дагуу Хороо байгуулах зарчмаа тогтож, гишүүн нэг бүрээр 2 өдөр хэлэлцсэний эцэст Монгол Улсын Бага Хурлын 1992 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 18 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн Ерөнхий Хороог дарга С.Лхагвасүрэн, нарийн бичгийн дарга Д.Баяндүүрэн, гишүүнээр Б.Авирмэд, Ч.Амарболд, О.Баяраа, Ц.Гунгаанямбуу, Б.Дангаасүрэн, Н.Батболд, Г.Маналжав, Д.Налжир, Н.Ринчиндорж, К.Тажебакед, Л.Хангай, Г.Цогтсайхан, Ж.Элбэгсайхан нарын бүрэлдэхүүнтэй байгуулжээ.



Сонгуулийн Ерөнхий Хорооны анхны гишүүд



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ-1993

Магистр Г.АРИУНБОЛД

Монгол Улсын Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн дагуу 1993 оны 6 дугаар сарын 6-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуулийг зохион байгуулав.

Улсын Их Хуралд суудал бүхий МАХН дангаараа, МҮАН, МСДН хамтран төрийн тэргүүн-Монгол Улсын Ерөнхийлөгчид нэрийг нь дэвшүүлсэн Лодонгийн Түдэв, Пунсалмаагийн Очирбат нар ард түмэндээ мөрийн хөтөлбөр, үзэл бодлоо тайлбарлан таниулж, МАХН болон МҮАН, МСДН-ын эвсэл нэр дэвшигчээ чөлөөтэй сурталчилсан нь Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуулийг ажил хэрэгч, өрсөлдөөнтэй, шударга байдалд явуулах боломжийг хангалаа.

Улсын хэмжээнд сонгуулийн нутаг дэвсгэрийн 33 хороо, хэсгийн хороо 1538, 349 салбар хороо байгуулагдан, тэдгээрт 13989 хүн ажиллалаа. Анхан шатны сонгуулийг эрхлэн явуулах эдгээр байгууллагад төрийн байгууллагын ажилтан, намуудын төлөөлөгч, ажилчин, малчин, сэхээтэн, ахмад настан, залуучууд зэрэг нийгмийн бүх бүлгийн төлөөлөл хамрагджээ.

Сонгуулийн хороод Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуулийг хуулийн хүрээнд, зохион байгуулалттай



Нэр дэвшигчид теле ярилцлагын өмнөхөн

явуулахад бүх анхаарлаа төвлөрүүлж, бэлтгэлийг зохих журмын дагуу хангаснаар анхан шатны сонгуулийн нэгдсэн дүнд нөлөөлөх ноцтой зөрчил гараагүйг Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хорооны дарга С.Лхагвасүрэн тэмдэглэж байв.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн үйл явцыг дэлхийн улс орнууд анхааралтай ажиглан харж байлаа. Санал хураалтын ажиллагааг АНУ, ОХУ, Япон, Франц,

БНСУ зэрэг 14 орны 28 ажиглагч, 20 гаруй сурвалжлагч, Улаанбаатар, Төв, Хөвсгөл аймгаар явж санал хураалтын байдлыг ажиглаж, сурвалжилжээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуульд нийт сонгогчдын 92,7 хувь нь оролцсон юм. Саналын хуудасны 3,5 хувь нь хүчингүй болсныг хасч тооцоход сонгуульд оролцсон нийт сонгогчдын 96,5 хувь нь нэр дэвшигчдийн төлөө саналаа өгсөн байна.



Сонгуулийн зарим хэсгийн хороонд сонгогч саналаа өгөхөөр ирэхдээ паспортгүй болон шилжүүлэг хийлгээгүй зэрэг зөрчил гарч байсныг тухай бүрт хуульд нийцүүлэн шийдвэрлэсэн бөгөөд Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын Бүгэлгээн багийн Зүүн хоолойн 86 дугаар хэсэг саналын гурван хайрцгийн хоёрыг нь хуульд заасан цагаас 45 минутын өмнө нээсэн учир нутаг дэвсгэрийн хороо Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн 38 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн хоёрт заасныг үндэслэн уг хэсгийн санал хураалтыг хүчингүй болсонд тооцож, дахин санал хураалт явуулсан байна.

Гэвч эдгээр нь Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуулийн нийт дүнд нөлөөлөөгүй.

Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуульд МҮАН, МСДН-ын эвслээс нэр дэвшсэн Пунсалмаагийн Очирбат нийт сонгогчийн 57,8 хувь, МАХН-аас нэр дэвшсэн Лодонгийн Түдэв 38,7 хувийн санал авсан байна.

Ийнхүү Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшиж, сонгогчдын олонхын санал авсан Пунсалмаагийн Очирбатыг Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж, бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргахыг Сонгуулийн ерөнхий хороо Улсын Их Хурлын чуулганд хүсэж, өргөн мэдүүлсэн юм.



СОНГУУЛИЙН
СУДАЛГААНЫ САН



UIH.MN
СУДАЛГААНЫ САН



04

ДУГААРЫН ЗОЧИН

- Д.Баяндүүрэн: “Сонгогчид үнэн, зөв мэдээлэлтэй байж, саналаа өгч, оролцох нь чухал”

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

25

Д.БАЯНДҮҮРЭН:

СОНГОГЧИД ҮНЭН, ЗӨВ МЭДЭЭЛЭЛТЭЙ БАЙЖ, САНАЛАА ӨГЧ, ОРОЛЦОХ НЬ ЧУХАЛ



Сонгуулийн Ерөнхий Хорооны Ажлын албаны дарга Д.Баяндүүрэнг дугаарын зочноор урьж, ярилцлаа.

- Орон нутгийн сонгуулийн онцлог нь юунд оршдог вэ?

- Сонгуулийн ерөнхий хороо сонгогчдод чиглэсэн мэдээ, мэдээлэл түлхүү өгөхийг зорьж ажилладаг. Сонгуулийн төрлийг ялгаж ойлгож байж сонгогчид тухайн сонгуулийн онцлог, мөн чанарыг илүү мэдэрч, түүнийг

дагаад идэвх, оролцоо ч нэмэгддэг. Хууль зааснаар бол төрийн эрх барих дээд байгууллага, хууль тогтоох байгууллага бол Монгол Улсын Их Хурал. Энэ ч утгаараа УИХ-д нийт ард түмний төлөөлөл сонгогддог. Харин Монгол Улсын Ерөнхийлөгч бол ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч. Орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал нь нутгийн өөрөө удирдах ёсны

төлөөлөгч учраас иргэдтэй илүү ойр ажилладаг. Өөрөөр хэлбэл, бидний амьдралд өдөр тутам тохиолддог асуудал, хүүхдийн тоглоомын талбай, хог ачих, гудамж талбайн гэрэлтүүлэг зэрэг тухайн нутаг, оронд тулгамдаж буй зүйлийг шийдвэрлэх, ажиллах төлөөллийг сонгох буюу орон нутгийн ИТХ-ын төлөөлөгчийг сонгох сонгууль юм. Тиймээс сонгогч сонгуульд

идэвхтэй оролцох, сонголтоо хийх чухал шаардлагатай байдаг.

- Энэ жил явагдах сонгуулийн цаг хугацааны хуваарь гарсан байсан. Хэдэн газарт сонгууль явагдах вэ?

- 2020 онд явагдсан орон нутгийн сонгуулиас хойш нөхөн, дахин сонгууль жилд нэг удаа явуулах хуулийн зохицуулалттай болсон. Ингэхдээ улсын төсвөөс нэгдсэн журмаар санхүүжүүлж, орон нутгийн Хурлын нөхөн болон дахин сонгуулийг жил бүрийн 6 дугаар сарын гуравдахь долоо хоногийн ням гарагт улс даяар нэгдсэн журмаар явуулахаар хуульчилсан. Энэ жилийн хувьд Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нөхөн болон дахин сонгуулийн санал авах ажиллагаа зургадугаар 18-ны өдрийн 07:00-20:00 цагт хүртэл хугацаанд явагдана. Бид 2022 оны 12 дугаар сараас эхлээд 2023 оны гуравдугаар сарын 20-ныг хүртэлх хугацаанд орон нутгийн хурлын нөхөн, дахин сонгуулийн судалгааг бүх аймаг, нийслэлээс авсан. Судалгаанаас үзэхэд энэ жил нийтдээ 17 аймгийн 33 сум,

нийслэлийн 2 дүүрэгт нөхөн болон дахин сонгууль явагдана. Шалтгаан нь АНСД-ийн ИТХ-ын төлөөлөгч төрийн албан хаагч болсон, өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн, нас барсан зэргээс дахин сонгууль явагдах нөхцөл үүсчээ.

- Цаашид жил бүр ийм сонгууль болох уу?

- Өмнө нь сонгууль явуулах шалтгаан, нөхцөл үүсэх бүрт тухайн шатны сонгуулийн хороо төсвөө орон нутгаасаа гаргаад, бие дааж явуулдаг байсан. Ямар асуудал тулгамддаг байсан гэхээр нөхөн сонгууль гарна, гарахгүй гэдгийг урьдчилан тооцох боломжгүй учраас зардал байхгүй, нөхөн болон дахин сонгууль явагддаггүй, зардал олддоггүй учир дутагдалтай байсан. Үүний цаана тухайн сонгогчийг төлөөлөх төлөөлөл нь нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагад байхгүй, өөрөөр хэлбэл, олон улсын гэрээ болон Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан эрх, эрх чөлөө зөрчигдөх нөхцөл байдалд хүрсэн учраас хууль тогтоогчдын зүгээс анхаарал хандуулж, нөхөн сонгуулийг жилд нэг удаа, нэгдсэн журмаар улсын хэмжээнд зохион байгуулна.

“

**ЭНЭ ЖИЛ
17 АЙМГИЙН
33 СУМ,
НИЙСЛЭЛИЙН
2 ДҮҮРЭГТ
НӨХӨН,
ДАХИН
СОНГУУЛЬ
ЯВАГДАНА.**



UIN.MN
СУДАЛГААНЫ САН

- Сонгуулийн төв байгууллагын зүгээс энэ удаагийн сонгуульд ямар чиг, үүрэгтэй оролцож байгаа бол?

- Ерөнхий удирдлагаар хангаж Сонгуулийн ерөнхий хороо ажиллана. Зардлыг улсын төсвөөс нэгдсэн журмаар санхүүжүүлж, нөхөн сонгууль явуулахаар шийдвэрлэсэн байгаа. Жил болгон нөхөн болон дахин сонгууль явагддаг.

- Сонгуулийн бэлтгэл ажил хэр хангагдав?

- Улсын хэмжээнд нэгэн зэрэг зохион байгуулагдах учраас ээлжит сонгуультай адил дутахааргүйгээр бэлтгэлийг хангаж ажиллаж байна. Сонгуулийн үйл ажиллагааны нэг гол онцлог нь хэн, хэзээ, юуг хийсэн байх ёстой вэ? гэдгийг хуулиар нарийвчлан тогтоосон байдаг болохоор яг тухайн хугацаанд нь

“

СОНГОГЧДОД ЗОРИУЛСАН МЭДЭЭ, МЭДЭЭЛЛИЙГ ТОГТМОЛ, ТАСРАЛТГҮЙ, ӨРГӨН ЦАР ХҮРЭЭТЭЙ, НЭЭЛТТЭЙ ТҮГЭЭХ ХЭРЭГЦЭЭ БИЙ.

”

тодорхой хуваарьт оруулаад зохион байгуулах шаардлага үүсдэг. Гуравдугаар сарын 20 гэхэд нөхөн, дахин сонгууль явуулна, явуулахгүй гэдэг шийдвэр эцэслэн гарсан байх ёстой. Үүнээс хойшхи хугацаанд зохион байгуулалтын ажил явагдаад эхэлнэ. Бид бэлтгэл ажлыг хангаад явж байна.

- Сонгогчдод хандаж юуг зөвлөх вэ?

- Ер нь бол аль ч сонгуульд, УИХ, Ерөнхийлөгч, орон нутгийн ялгалгүй сонгогчид үнэн, зөв мэдээлэлтэй оролцож, сонголтоо хийх явдал чухал байдаг. Сонгуулийн ерөнхий хорооны зүгээс



энэ асуудалд ихээхэн ач холбогдол өгч, ажиллаж байна. Сонгогчдод зориулсан мэдээ, мэдээлэл, хууль тогтоомжийг тайлбарлан таниулах чиглэлд өмнө нь ээлжит сонгуулийн жилд л "Ийм зүйл болох гэж байна" гэсэн мэдээллийг өгдөг байсан бол одоо цаашид тогтмол, өргөн хүрээнд нээлттэй мэдээлж явна. Энэ хүрээнд манай Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээлэл, судалгаа, сургалтын төв олон улсын болон дотоодын төрийн бус байгууллагуудтай хамтраад сонгогчдод чиглэсэн боловсрол олгох ажиллагаанд нэлээд өргөн хүрээтэй арга хэмжээ авч ажиллаж байгаа. Гол зарчим нь өнөөдөр цахим орчин дахь хэрэглээ, мэдээлэл авах суваг олширсон, үүнийг дагаад худал, эх сурвалж тодорхойгүй, сонгогчдыг төөрөгдүүлэх, зөвөөр сонголтоо хийхэд сөрөг нөлөө үзүүлэх хандлага байж болзошгүй хэмээн үзэж бид сургалтдаа мэдээллийн эх сурвалжаа нягтлах, хэрхэн нягталж, судлах арга зэргийг энгийнээр тайлбарлан таниулахыг хичээдэг. Тухайлбал, цахим орчинд явж буй мэдээллийн давалгааг дагаж савлахгүйгээр, хөндлөнгийн нөлөөгүйгээр сонголтоо хийх боломж нөхцлийг бүрдүүлэх чиглэлд анхаарч ажиллаж байгаа.

- "Хариуцлагатай сонгогч" бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд сургагч багш нарыг бэлтгэжээ. Тэдний үүрэг, оролцоо ямар байгаа вэ?

- НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран 21 аймаг, 9 дүүрэгт сонгуулийн боловсрол олгох сургагч багш тус бүр 2-ыг бэлдэж, Сонгуулийн ерөнхий хорооны Мэдээлэл, судалгаа, сургалтын төвийн орон нутаг дахь сургагч багш гэсэн статустайгаар томилон ажиллуулж байгаа. Тэдгээр багш нар маань сонгуульд анх удаа

саналаа өгч, оролцох гэж буй залуу сонгогчдод чиглэсэн сонгуульд оролцохын ач холбогдол, үнэ цэнэ, хэрхэн хариуцлагатай оролцох вэ? зэрэг ойлголт, мэдлэг олгох "Хариуцлагатай сонгогч" сургалтыг зохион байгуулж, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Энэ жил сургалтууд үргэлжилнэ. Мөн бид "Сонгогчдын боловсрол төв" ТББ, "ЛИЙД төгсөгчдийн холбоо" ТББ-тай

Санамж бичиг байгуулж, сонгогчдын идэвх, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна. Өөрөөр хэлбэл, бид сонгогчдод уламжлалт арга хэлбэрээр мэдээ, мэдээлэл өгөхөөс гадна уламжлалт бус мэдээллийн хэрэгслийг ашиглан, залуусын мэдээлэл авах суваг, арга хэлбэр, хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн тогтмол, өргөн цар хүрээтэй үйл ажиллагаа явуулна.

Ярилцсан: З.Бадмаараг
Сонгуулийн ерөнхий хорооны
хэвлэлийн төлөөлөгч



“ДУГАРДОРЖИЙН БАЯНДҮҮРЭН ЗОЧНЫ НАМТАР

Тэрбээр Сонгуулийн Ерөнхий Хороонд 1992 оноос өнөөг хүртэл Нарийн бичгийн дарга, ахлах референт, Ажлын албаны дарга, гишүүнээр ажиллаж байна. Тэрээр эрхзүйч мэргэжилтэй, хууль зүйн ухааны магистр, төрийн албаны Тэргүүн түшмэл, тэргүүн зэрэгтэй.

Улсын Их Хурлын 1992, 1996, 2000, 2004, 2008, 2012, 2016, 2020 оны ээлжит сонгууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1993, 1997, 2001, 2005, 2009, 2013, 2017, 2021 оны ээлжит сонгуулиуд болон Орон нутгийн 1992, 1996, 2000, 2004, 2008, 2012, 2016, 2020 оны сонгууль, мөн хугацаанд явагдсан УИХ-ын нөхөн сонгуулиудыг удирдан зохион байгуулж, сонгуулиудын зардлын төсөв, тойрог байгуулах төсөл зохиох, тооцох, батлуулах, сонгуулийн асуудлаар судалгаа хийх, сонгуулийн ажлыг төлөвлөхөөс эхлээд сонгуулийн хороод байгуулах, сургалт зохион байгуулах, сонгуулиудын үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журам, заавар зөвлөмж, сонгуулийн ажилд хэрэглэгдэх үнэмлэх, сонгуулийн дүн мэдээний маягтын загвар боловсруулж батлуулах, саналын хуудас, сонгогчийн үнэмлэх хэвлүүлэх, сонгуулийн дүнг улсын хэмжээнд нэгтгэх, нийтэд мэдээлэх зэрэг ажлыг зохион байгуулж ажиллажээ.

ОХУ, БНСУ, АНУ, БНКиру, ХБНГУ-ын сонгуулиудыг ажиглаж, туршлага хуримтлуулсан байна. Сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгоход хувь нэмрээ оруулж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Орон нутгийн сонгуулийн тухай хуулийг боловсруулах, УИХ-ын сонгуулийн тойрог байгуулах УИХ-ын Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан туршлагатай.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны сонгууль, УИХ-ын 2012, 2016 оны сонгууль, Нийслэлийн ИТХ-ын сонгууль, Аймаг, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулиар Монгол Улсад анх удаа сонгуулийн автоматжуулсан систем нэвтрүүлэх, сонгогчийн бүртгэл, санал авах, тоолох, дүн гаргах төхөөрөмж ашиглах ажлыг удирдан зохион байгуулж, Сонгуулийн автоматжуулсан системийн техник, хэрэгслийг сонгон авах, турших, гэрээ хэлцэл байгуулах ажлыг удирдсан хүн бол Д.Баяндүүрэн юм.

Монгол Улс анх удаа гадаад оронд ажиллаж амьдарч буй сонгогчдын саналыг авах ажлыг УИХ-ын 2012 оны болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013, 2017, 2021 оны ээлжит сонгуулиар зохион байгуулсан бөгөөд уг ажлыг удирдан зохион байгуулж, Гадаад харилцааны яамтай хамтарсан комиссын бүрэлдэхүүнд орж ажиллан, хуулийн дагуу амжилттай гүйцэтгэжээ. БНМАУ-ын АИХ-ын II хуралдааныг зохион байгуулах хэсгийн бүрэлдэхүүнд багтаж, Монгол Улсын шинэ Үндсэн хуулийг батлахад оролцсон түүхтэй.

2023

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН

НӨХӨН ДАХИН СОНГУУЛЬ ЦАГ ХУГАЦААНЫ ХУВААРЬ

Сонгуулийн ерөнхий хорооны 2023 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 01 дугаар тогтоолоор Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны нөхөн болон дахин сонгуулийг зохион байгуулах цаг хугацааны хуваарийг баталлаа. Сонгуулийн үйл ажиллагаа явуулах цаг хугацааны хуваарьтай танилцана уу.

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2023 ОНЫ НӨХӨН БОЛОН ДАХИН СОНГУУЛИЙН ЦАГ ХУГАЦААНЫ ХУВААРЬ	
САНАТ АВАХ, ӨДӨР 6.18	ЦАГ 07:00-20:00
Хурлын 3.21-нөөс өмнө СОНГУУЛЬ ТӨВЛӨН БАНГУУЛАХ	Хурлын 12.6 СОНГУУЛИЙН ТОНДОР БАНГУУЛАХ
Хурлын 12.10 СОНГУУЛИЙН ХЭДЭГ БАНГУУЛАХ	Хурлын 24.4 СОНГУУЛЬ ТӨВЛӨН ЗАРЛАСАН ШИДЭЛЭРЭЙН ХҮРГҮҮЛЭХ
Хурлын 20.4 СОНГУУЛИЙН ХЭДЭГ ЦАХИВ ХУДАСТ БАЙГУУЛАХ	

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2023 ОНЫ НӨХӨН БОЛОН ДАХИН СОНГУУЛИЙН ЦАГ ХУГАЦААНЫ ХУВААРЬ	
САНАТ АВАХ, ӨДӨР 6.18	ЦАГ 07:00-20:00
Хурлын 4.01-нөөс өмнө АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН СОНГУУЛИЙН ХОРООТ БАНГУУЛАХ	Хурлын 17.2 СҮМ, ДҮҮРГИЙН СОНГУУЛИЙН ХОРООТ БАНГУУЛАХ
Хурлын 24.1 НИЙСЛЭЛИЙН ХОРООТ СОНГУУЛИЙН ХОРООТ БАНГУУЛАХ	Хурлын 20.8 СОНГУУЛИЙН ХОРООТ БАНГУУЛАХ
Хурлын 25.1 НИЙСЛЭЛИЙН ХОРООТ БАНГУУЛАХ	Хурлын 27.2 НИЙСЛЭЛИЙН ХОРООТ БАНГУУЛАХ

АЛМАК, ИМЛӨСӨЗ, СӨМ, ДУРГУУН ИРГЭЭДИЙН ТӨӨ СӨНӨТӨНДӨЙН
ХҮРГАЙН ЭЭЗЭНЭЙ НӨХӨН БОЛОН ДАХИЙ СӨНӨТҮҮНЭЙН
ЦАГ ДУГААНЫ БУВААРЬ

САНАЛАВАХ, БЭДЭР **6.18** ЦАГ **07:00-20:00**

11111111

5

-р САР

11111111

Хүрнэйд 18.1

6.4

-нөс өдөр

ЭДСӨННӨ ХӨРӨӨГ
БАЙГУУЛАХ

11111111

Хүрнэйд 18.2

6.5

-нөс өдөр

СУРГАЛТ ЗОХИОН
БАЙГУУЛАХ

11111111

Хүрнэйд 20.1,2

5.4

-нөс өдөр

НӨР ДЭМЖЛЭГДЭН
АНХААГАЛ

11111111

Хүрнэйд 21.2,2

5.13

-ны дотор

НӨР ДЭМЖЛЭГДЭН
САНГАТ САНГАЙ ИРГЭЭ

11111111

Хүрнэйд 21.3

НӨР ДЭМЖЛЭГДЭН СУРГАЛТ
ЗОХИОН

НӨР ДЭМЖЛЭГДЭН
АНХААГАЛ

11111111

Хүрнэйд 21.4

6.13

-ны дотор

НӨР ДЭМЖЛЭГДЭН СУРГАЛТ
ЗОХИОН

АЛМАК, ИМЛӨСӨЗ, СӨМ, ДУРГУУН ИРГЭЭДИЙН ТӨӨ СӨНӨТӨНДӨЙН
ХҮРГАЙН ЭЭЗЭНЭЙ НӨХӨН БОЛОН ДАХИЙ СӨНӨТҮҮНЭЙН
ЦАГ ДУГААНЫ БУВААРЬ

САНАЛАВАХ, БЭДЭР **6.18** ЦАГ **07:00-20:00**

11111111

5

-р САР

11111111

Хүрнэйд 18.1

6.4

-нөс өдөр

ЭДСӨННӨ ХӨРӨӨГ
БАЙГУУЛАХ

11111111

Хүрнэйд 18.2

6.5

-нөс өдөр

СУРГАЛТ ЗОХИОН
БАЙГУУЛАХ

11111111

Хүрнэйд 20.1,2

5.4

-нөс өдөр

НӨР ДЭМЖЛЭГДЭН
АНХААГАЛ

11111111

Хүрнэйд 21.2,2

5.13

-ны дотор

НӨР ДЭМЖЛЭГДЭН
САНГАТ САНГАЙ ИРГЭЭ

11111111

Хүрнэйд 21.3

НӨР ДЭМЖЛЭГДЭН СУРГАЛТ
ЗОХИОН

НӨР ДЭМЖЛЭГДЭН
АНХААГАЛ

11111111

Хүрнэйд 21.4

6.13

-ны дотор

НӨР ДЭМЖЛЭГДЭН СУРГАЛТ
ЗОХИОН

АЛМАК, ИМЛӨСӨЗ, СӨМ, ДУРГУУН ИРГЭЭДИЙН ТӨӨ СӨНӨТӨНДӨЙН
ХҮРГАЙН ЭЭЗЭНЭЙ НӨХӨН БОЛОН ДАХИЙ СӨНӨТҮҮНЭЙН
ЦАГ ДУГААНЫ БУВААРЬ

САНАЛАВАХ, БЭДЭР **6.18** ЦАГ **07:00-20:00**

11111111

5

-р САР

[illegible]

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023-оны **НӨӨЛӨН БОСОН ДАХИН СОНГУУЛИЙН ЦАГ** ХУГАЦААНЫ ХУВААРЬ

САНАЛ АВАХ, ӨДӨР **6.18** ЦАГ **07:00-20:00** **6-р CAP**

Хуульч 62.4 -нээс өмнө ЗӨВӨӨНӨЙ БУЛТГАВЧИРСАН САНАЛЫН ХАРИУДААР САНАЛ АГЫН ХАСЧЛАЛ СЭН, ДҮГЭЙН СОНГУУЛИЙН ХӨРӨНӨ ХЭРГҮҮЛЭХ 62.11-нээс өмнө Хуульч 62.4-нээс өмнө	Хуульч 62.5 -нээс өмнө ЗӨВӨӨНӨЙ БУЛТГАВЧИРСАН САНАЛЫН ХАРИУДААР САНАЛ АГЫН ХАСЧЛАЛ СЭН, ХӨРӨНӨ ХЭРГҮҮЛЭХ Хуульч 62.5-нээс өмнө
Хуульч 62.2 -нээс өмнө ЗӨВӨӨНӨЙ БУЛТГАВЧИРСАН САНАЛЫН ХАРИУДААР САНАЛ АГЫН ХАСЧЛАЛ СЭН, ХӨРӨНӨ ХЭРГҮҮЛЭХ 62.11-нээс өмнө Хуульч 62.2-нээс өмнө	Хуульч 62.7 -нээс өмнө АЖИТАЛГААР БИРЭГДЭХ ХӨРӨНӨ ХЭРГҮҮЛЭХ Хуульч 62.7-нээс өмнө
Хуульч 62.3 -нээс өмнө САНАЛЫН ХӨРӨНӨ ХЭРГҮҮЛЭХ Хуульч 62.3-нээс өмнө	Хуульч 62.8 -нээс өмнө АЖИТАЛГААР БИРЭГДЭХ ХӨРӨНӨ ХЭРГҮҮЛЭХ Хуульч 62.8-нээс өмнө

МАХАД УИХААНЫ АТЛАС, 1974-2023 ОНЫ
МАХАД УИХААНЫ АТЛАС
МАХАД УИХААНЫ АТЛАС, 1974-2023 ОНЫ

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023-оны **НӨӨЛӨН БОСОН ДАХИН СОНГУУЛИЙН ЦАГ** ХУГАЦААНЫ ХУВААРЬ

САНАЛ АВАХ, ӨДӨР **6.18** ЦАГ **07:00-20:00** **6-р CAP**

Хуульч 23.2 -нээс өмнө СОНГОГЧИНЫ ХӨРӨНӨ ХЭРГҮҮЛЭХ ХӨРӨНӨ ХЭРГҮҮЛЭХ Хуульч 23.2-нээс өмнө	Хуульч 62.1 09:00-20:00 цаг ЗӨВӨӨНӨЙ БУЛТГАВЧИРСАН ХАРИУДААР САНАЛ АВАХ Хуульч 62.1-нээс өмнө
2023.6.18 САНАЛ АВАХ ӨДӨР Хуульч 24.1 ИРГЭДИЙН ХАРИУДААР ХӨРӨНӨ ХЭРГҮҮЛЭХ Хуульч 24.1-нээс өмнө	Хуульч 24.1 ИРГЭДИЙН ХАРИУДААР ХӨРӨНӨ ХЭРГҮҮЛЭХ Хуульч 24.1-нээс өмнө
Хуульч 72.4 -нээс өмнө ТӨЛӨӨН БОСОН СОНГОГЧИНЫ ХӨРӨНӨ ХЭРГҮҮЛЭХ Хуульч 72.4-нээс өмнө	Хуульч 72.5 -нээс өмнө СОНГОГЧИНЫ ХӨРӨНӨ ХЭРГҮҮЛЭХ Хуульч 72.5-нээс өмнө

МАХАД УИХААНЫ АТЛАС, 1974-2023 ОНЫ
МАХАД УИХААНЫ АТЛАС
МАХАД УИХААНЫ АТЛАС, 1974-2023 ОНЫ

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023-оны **НӨӨЛӨН БОСОН ДАХИН СОНГУУЛИЙН ЦАГ** ХУГАЦААНЫ ХУВААРЬ


САНАЛ АВАХ, ӨДӨР **6.18** ЦАГ **07:00-20:00** **СОНОХ УУСНЫ ДАВНА**

Хуульч 56.5 -нээс өмнө ГЭВЭЭНӨЙ ХУУЛЬЧ, АЖИТАЛГААР БИРЭГДЭХ ХӨРӨНӨ ХЭРГҮҮЛЭХ Хуульч 56.5-нээс өмнө	Хуульч 56.3 -нээс өмнө ТӨЛӨӨН БОСОН СОНГОГЧИНЫ ХӨРӨНӨ ХЭРГҮҮЛЭХ Хуульч 56.3-нээс өмнө
Хуульч 56.3 -нээс өмнө ТӨЛӨӨН БОСОН СОНГОГЧИНЫ ХӨРӨНӨ ХЭРГҮҮЛЭХ Хуульч 56.3-нээс өмнө	Хуульч 57.1 -нээс өмнө НОР ДЭВЭЭНӨЙ СОНГОГЧИНЫ ХӨРӨНӨ ХЭРГҮҮЛЭХ Хуульч 57.1-нээс өмнө
Хуульч 57.1 -нээс өмнө НОР ДЭВЭЭНӨЙ СОНГОГЧИНЫ ХӨРӨНӨ ХЭРГҮҮЛЭХ Хуульч 57.1-нээс өмнө	

МАХАД УИХААНЫ АТЛАС, 1974-2023 ОНЫ
МАХАД УИХААНЫ АТЛАС
МАХАД УИХААНЫ АТЛАС, 1974-2023 ОНЫ

УИХ.МН
СУДАЛГААНЫ САН





05

СУДАЛГАА


- Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн үйл явцад хийсэн дүн шинжилгээ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

35

ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИН ДЭХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦОО

(ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙН ЖИШЭЭН ДЭЭР)



Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс
НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр

КОЙКА олон улсын байгууллага
Монголын эмэгтэйчүүдийн холбоо

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

НҮБ-ын Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн тухай конвенцод эмэгтэйчүүд аливаа алагчлалгүйгээр эрэгтэйчүүдийн нэгэн адил эрх тэгш байдлаар бүх сонгуульд саналаа өгөх, сонгогдвол зохих бүх байгууллагад сонгогдох, төрийн алба хаших болон үндэсний хууль тогтоомжийн дагуу тогтоосон төрийн бүхий л үүргийг гүйцэтгэх зэрэг эрхийг баталгаажуулсан¹. Тус конвенцын заалтууд нь Монгол Улсын Үндсэн хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай, Төрийн албаны тухай, УИХ-ын сонгуулийн

тухай, Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль зэрэг үндэсний хууль тогтоомжид тусгалаа олжээ. 2021 онд Монгол Улс Дэлхийн жендэрийн зөрүүтэй байдлын индексн “Улс төрийн эрх мэдэл” үзүүлэлтээр 0.122 оноогоор 116 дугаар байрт орсон нь хамгийн хангалтгүй үзүүлэлттэй байна². Мөн Олон улсын парламентын холбооны нэгдсэн мэдээллээс үзэхэд 2021 оны байдлаар нийт улс орнуудын парламент дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь дунджаар 25.8 хувьтай байхад Монгол Улсынх 17.1 хувь бөгөөд Азийн бүс нутгийн дунджаас 21 хувиас доогуур үзүүлэлтэй байгаа нь харагдаж байна³.

Монгол Улсын нийт сонгогчдын 51 хувь нь эмэгтэйчүүд

1 НҮБ-ын 1952 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн тухай конвенцыг баталж, 1954 оны 07 дугаар сарын 07-ны өдөр хүчин төгөлдөр болсноор Монгол Улс 1981 онд нэгдэн орсон. www.legalinfo.mn/mn/detail/1293


2 Я.Төгөлдөр, Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо, жендэрийн эрх тэгш байдлыг хангах зөвлөмжүүд/ Жендэр ба үндэсний чуулган/ 2021.11.09, Улаанбаатар.

3 IPU.(2021).Inter-Parliamentary Union. Retrieved from Woman in parliament in 2021: <https://www.ipu.org/our-impact/gender-equality>

байгаагаас 2020 оны ИТХ-ын сонгуульд саналаа өгсөн сонгогчдын 55.9 хувь нь эмэгтэйчүүд байв. Нэр дэвшсэн эмэгтэйчүүдийн тоог авч үзвэл 2016 онд 129, 2020 онд 151 болсон нь өмнөх сонгуулийн жилтэй харьцуулахад 17 хувиар өсжээ. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд нийт 1106 төлөөлөгч байгаагаас 80.4 хувь нь эрэгтэй, 19.6 хувь нь эмэгтэй байна⁴.

Тоо баримтаар аймаг/нийслэлийн ИТХ-ын даргаар 2016-2019 онд нэг ч эмэгтэй хүн сонгогдоогүй бол 2020 онд 2 эмэгтэй сонгогдсоноос үзэхэд орон нутгийн түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо хангалтгүй байгааг харуулж байна. Түүнчлэн манай улсын дээд боловсролтой эмэгтэйчүүдийн хувь өссөн үзүүлэлтэй байдаг хэдий ч шийдвэр гаргах түвшинд ялангуяа хууль тогтоох дээд байгууллага болон Аймаг, нийслэлийн ИТХ-д Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан квотуудын түвшинд хүрээгүй байсаар байна.

Орон нутгийн сонгууль дахь эмэгтэйчүүдийн оролцоо, 2016-2020 он



Сурвалж: Төрийн албаны зөвлөл, УСХ-ны www.1212.mn, ЖҮХ АА.

Энэхүү судалгааг НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, КОЙКА олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр ХЭҮК болон МЭХ хамтран 2022 оны нэгдүгээр сараас эхлэн 03-р сар хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэлээ. Судалгаагаар ИТХ-д нэр дэвшигч эмэгтэйчүүдийн улс төрийн амьдралын туршлага, хүний эрх болон жендэрийн талаарх ойлголт, мэдлэг, улстөрч эмэгтэйчүүдэд хандах олон нийтийн хандлага, сонгуулийн үйл явцад эмэгтэй улстөрчдөд тулгарсан эрхийн зөрчил, түүнийг шийдвэрлэсэн байдлыг тодорхойлохыг зорьсон юм.

Судалгааг 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүргийн

төлөөллөөс бүсчилсэн хэлбэрээр авч, үндэсний түвшинд явууллаа.

...Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд нэр дэвшигч эмэгтэйчүүдийн улс төрийн туршлага, оролцоо, сонгуулийн явцад тулгарсан эрхийн зөрчил, түүнийг шийдвэрлэсэн байдлыг тодруулахдаа орон нутгийн 631 эмэгтэйг асуулга судалгаанд хамруулав.

Судалгаанд хамрагдсан оролцогчид, орон нутгаар (n=631)



Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны сонгуульд нийт 2174 нэр дэвшигч, 2020 онд 2172 нэр дэвшигч өрсөлдсөн бөгөөд хүйсийн мэдээллийг нэгтгэж гаргаагүй нь эх олонлогийг тооцоход хүндрэлтэй байв...

Судалгаанд оролцогчдын ерөнхий шинж байдал:

Судалгаанд хамрагдсан эмэгтэй нэр дэвшигчдийн 628 буюу 99.5 хувь нь эмэгтэй, 3 буюу 0.5 хувь нь ЛГБТК байв. Насны бүтцийн хувьд 24-77 настай нийт 631 эмэгтэй хамрагдсан бөгөөд дундаж нас 44. Нийт оролцогчдыг насны ангиллаар нь авч үзвэл 18-35 насныхан 18.4 хувь, хамгийн олон нь 36-45 насныхан 38.8 хувь, 46-55 насныхан 33.1 хувь, 56-аас дээш насныхан 9.7 хувийг эзэлж байна. Судалгааны үр дүнгээр 36-55 насныхан 71.9 хувь буюу зонхилох хандлагатай байгаа нь эмэгтэйчүүдийн хувьд улс төрийн карьер 36 наснаас эхэлдэг болохыг харуулж байна.

...Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд нэр дэвшсэн эмэгтэйчүүдийн боловсрол болон мэргэжлийн чиглэлийг судлахад 60.9 хувь нь дээд боловсролтой, 17.7 хувь нь магистр, харин докторын зэрэгтэй оролцогч нэг байв. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд нэр дэвшсэн эмэгтэйчүүдийн 30.3 хувь нь багш, боловсрол судлал, 16.8 хувь нь анагаах ухаан, 12.8 хувь нь нийгэм, эдийн засаг, 12.4 хувь нь бизнесийн удирдлагын чиглэлээр мэргэжил эзэмшсэн байна.

Судалгаанд оролцогчдын 500 нэр дэвшигч буюу 79.3 хувь нь сум, дүүргийн ИТХ-д, 131 нэр дэвшигч буюу 20.7 хувь нь Аймаг, нийслэлийн ИТХ-д нэрээ дэвшүүлсэн байна. Үүнээс үзэхэд сум, дүүргийн ИТХ-д гол төлөв эмэгтэйчүүд өрсөлдөх боломж их байгаа нь харагдлаа...

4 УСХ. (2021, 08 10). Монгол Улсын статистикийн эмхэтгэл-2020. Улаанбаатар, Монгол.

СУДАЛГААНЫ ГОЛ ҮР ДҮН, САНАЛ

Энэхүү судалгаанд тоон судалгааны үр дүнг баримт бичгийн шинжилгээний өгөгдлөөр баталгаажуулсан бөгөөд судалгааны явцад нийтлэг шинжтэй хэд хэдэн гол асуудал байгаа нь харагдсан. Монгол Улсад шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхтэй холбоотой нэн тэргүүнд шийдвэрлэх ёстой, хамгийн тулгамдсан асуудлыг зургаан үндсэн үр дүнд тоймлон харууллаа. Эдгээр үр дүнг судалгааны тайланд тайлбарласан байх ба үр дүнгийн дагуу авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны саналыг тайланд тусгасан болно.



ҮР ДҮН 1: Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд үндэсний эрх зүйн орчин бүрдсэн ч хэрэгжилт хангалтгүй байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт улс төрийн нам, үйлдвэрчний эвлэлийн болон олон нийтийн бусад байгууллагад гишүүнээр эвлэлдэн нэгдэх, тэдгээрийн үйл ажиллагаанд оролцох эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш эрх, тэгш боломжийг хязгаарлах, ялгаварлан гадуурхахыг хориглоно гэжээ. Мөн хуулийн 8.2 дахь хэсэгт бүх шатны сонгуульд нэр дэвшигч эрэгтэй, эмэгтэй хүний сонгуулийн сурталчилгаанд зориулан улс төрийн намаас үзүүлэх санхүүгийн дэмжлэг ижил хэмжээтэй байна гэж тусгасан. Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 11.2.8 дахь заалтад Сонгуульд нэр дэвшүүлэх, боловсон хүчнийг шилж сонгох, хүйсийн тэгш байдлыг хангах зарчмыг намуудын дүрэмд тусган мөрдөхийг заасан. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 29.2 дахь хэсэгт зааснаар “Нам, эвслээс нэр дэвшиж байгаа нэр дэвшигчийн 20-иос доошгүй хувь нь аль нэг хүйсийн нэр дэвшигч байна” гэж заасан байна⁵. Энэ нь эрэгтэй, эмэгтэй хэн ч байхаар зохицуулсан боловч практикт илүүтэйгээр нэр дэвших квотын 20-иос доошгүй хувиар тогтоохдоо эмэгтэйчүүдэд илүү хамааруулж байгаа нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах нөхцөл бүрдэхгүй байна гэж үзэхээр байна. Тухайлбал, 2020 оны сонгуульд нам эвслүүд нь нэр дэвшигчдийг дэвшүүлэхдээ холбогдох

хуулийн заалтыг хангаж байгаа боловч суудал авсан байдлыг харахад Аймаг, нийслэлийн ИТХ-д эрэгтэйчүүд 85 хувь, эмэгтэйчүүд 15 орчим хувийг эзэлж байгаа нь хүйсийн тэнцвэрт байдал хэт зөрүүтэй харагдаж байна⁶.

Эмэгтэйчүүдийн улс төрийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож буй хугацааг тодруулахад оролцогчдын 225 буюу 35.7 хувь нь 11 жилээс дээш, 170 буюу 27 хувь нь 3-6 жил, 127 буюу 20.2 хувь нь 2 хүртэл жил, 108 буюу 17.1 хувь нь 6-10 жил гэж хариулсан байна. Судалгаанд хамрагдсан 3 эмэгтэй тутмын нэг нь 11 дээш жил улс төрд тогтвортой байгаа боловч нам дотроо эзлэх байр суурь жирийн гишүүнээс гадна тодорхой албан тушаалд ахихгүй, хэвээрээ байна. Улс төрийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон хугацааг намын гишүүнчлэлээр авч үзвэл МАН-ын гишүүдийн 39.7 хувь, АН-ын гишүүдийн 34.2 хувь болон бусад намын гишүүдийн 40.7 хувь нь 11 жилээс дээш байв.

Судалгаанд хамрагдсан нийт 631 оролцогчийн улс төрийн оролцоог судлан үзэхэд 2016 онд 48 эмэгтэй, харин 2020 онд 367 эмэгтэй ИТХ-ын сонгуульд нэрээ дэвшүүлэн өрсөлдсөнөөс 40 эмэгтэй нь 2016 онд сонгуульд өрсөлдсөн туршлагатай байв. Үүнээс үзэхэд эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо жил ирэх тусам нэмэгдэх хандлага ажиглагдав.

Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 41 хувь (дундаж 41%, медиан 38%) нь нам дотроо 20-40 хувийн квотыг тогтоодог болохыг баталсан. Уг хариултыг намын гишүүнчлэлээр нь харуулбал,

Хүснэгт 3. Намын квотыг тогтоож буй байдал (n=617)

Намууд	Хүйсийн тэнцвэртэй байдлыг анхаарах	40% дээш дэмжлэг	20-40% дэмжлэг	20% хүртэлх дэмжлэг	Квот тогтоодоггүй	Бусад	Бүгд /хувиар/
МАН	19.9	8.8	38.4	20.9	7.1	5.1	100
АН	15.5	13.0	48.3	12.6	7.6	2.9	100
ХҮН	100						100
Бусад нам	19.1	10.6	23.4	6.4	29.8	10.6	100

МАН-ын гишүүн эмэгтэйчүүдийн 38.4 хувь болон АН-ын гишүүн эмэгтэйчүүдийн 48.3 хувь нь 20-40 хувийг тогтоодог гэж хариулсан. Харин бусад намын хувьд “квот тогтоодоггүй” гэсэн хариултыг хамгийн олон оролцогч өгчээ. ХҮН-ын гишүүн 2 оролцогч байгаа нь нийт оролцогчийн тоотой харьцуулахад хэт цөөн тул тус намын оролцогчдын төлөвийг тодорхойлоход хангалтгүй байна.

5 УИХ. (2020.01.30). Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. Retrieved from Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль: <https://legalinfo.mn/mn/detail?lawid=15125>

6 ХЭҮК. (2021.10.15). 2012, 2016, 2020 оны ээлжит Улсын Их Хурал болон Орон нутгийн сонгуульд нэр дэвшигчдийн жендэрийн тэгш байдлын мэдээллийн танилцуулга. Улаанбаатар хот,

Эмэгтэй нэр дэвшигчдэд квотыг олгохдоо хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг үндэслэл болгодог байна. Судалгаанд оролцогчдын 261 буюу 27.4 хувь нь “олон жил намын гишүүнээр тогтвортой, идэвхтэй ажилласан”, 256 буюу 26.9 хувь нь “Намдаа нөлөө бүхий танил, хамаатан садны дэмжлэг өндөр” гэсэн хариултыг өгчээ. Харин “Намын удирдах албан тушаал хашсан”, “Намдаа ихээхэн хэмжээний мөнгөн хандив өгдөг” гэсэн хариултыг тус бүр 4.8 хувь нь сонгосон.



ҮР ДҮН 2: Орон нутгийн сонгуульд дахь эмэгтэйчүүдийн оролцоонд нас залуу, гэрлэлтийн баталгаатай, намын гишүүнчлэлтэй, төрийн байгууллагад ажилладаг, тухайн амьдарч буй орон нутагтаа тогтвор суурьшилтай 8-аас дээш жил амьдарсан байдал зэрэг хүчин зүйл нөлөөлж байна.

Судалгааны ажлын хүрээнд эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог тодорхойлох олон хүчин зүйлийн регрессийн шинжилгээнд судалгаанд хамрагдсан 631 хүний мэдээллийг ашиглав. Шинжилгээний загварт үл хамаарах хувьсагчаар эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог авч, бусад ижил төстэй судалгаанд үндэслэн үл хамаарах хувьсагчдыг сонгосон болно.

Хүснэгт 4. Эмэгтэйчүүдийн улс төрд идэвхтэй оролцох байдалд нөлөөлөгч хүчин зүйлсийн шинжилгээ

Хамааран хувьсагч: Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо нэмэгдэх байдал		
Үл хамаарах хувьсагчид	(1) загвар	(2) загвар
Сонгуульд нэр дэвшигч_нас_Ахимаг	-.108** (.044)	-.113*** (.044)
Сонгуульд нэр дэвшигч_Амьдран суугаа газар_Хамгийн багадаа 8 жил	.084* (.047)	.082* (.047)
Сонгуульд нэр дэвшигч_Гэр бүлийн байдал_Гэрлэсэн	.078*** (.025)	.066*** (.023)
Сонгуульд нэр дэвшигч_Ажлын байр_Төрийн байгууллага	.069** (.031)	.074** (.031)
Сонгуульд нэр дэвшигч_Намын гишүүн	.077*** (.025)	.072*** (.024)
Сонгуульд нэр дэвшигч_Үндэстэн_Халх		.023 (.02)
Сонгуульд нэр дэвшигч_Шашин_Будда		.034 (.032)
Сонгуульд нэр дэвшигч_Боловсролын түвшин		.061 (.049)

Сонгуульд нэр дэвшигч_Гэр бүл_Санхүүгийн нөхцөл байдал		.034
		(.034)
Тогтмол	.084***	.051*
	(.017)	(.029)
Ажиглалт	631	631
R-квадрат	.135	.143
Статистикийн ач холбогдол		
*** p<.01, ** p<.05, * p<.1		

Регрессийн (2) загварт Нас хувьсагчийн үнэлэгдсэн коэффициент -0.044 байгаа нь судалгаанд хамрагдсан оролцогчдын нас нэг нэгжээр залуужихад 0.044-өөр өсөх магадлалтай байгааг 95 хувийн итгэх завсарт харуулж байв (Хүснэгт-3). Өөрөөр хэлбэл, эмэгтэйчүүдийн нас залуужих тусам улс төрийн оролцоо нэмэгдэж буйг илтгэж байна.

Эмэгтэй улстөрчдийн гэрлэлтийн байдлыг судлан үзэхэд 87.1 хувь нь гэрлэлтийн баталгаатай бол 4 хувь нь ганц бие эмэгтэйчүүд байв. Өөрөөр хэлбэл, гэрлэсэн, гэр бүлийн зүгээс дэмжин тусалдаг байдал нь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлдэг болох нь шинжилгээгээр батлагдаж байна. (1 загвар, p<.05), (2 загвар, p<.05).

Шинжилгээний үр дүнгээр төрийн байгууллагад ажилладаг байх нь улс төрийн оролцоог нэмэгдүүлдэг гэж үзэж болохоор байна. (1 загвар, p<.05), (2 загвар, p<.05). Улс төрч эмэгтэйчүүд 90.5 хувь нь тухайн амьдран суугаа газартаа тогтвор суурьшилтай буюу 8 жилээс дээш хугацаанд амьдарч байгаа бол 4 жил хүртэл амьдарсан эмэгтэйчүүдийн хувь 4.3 байгаа нь тухайн орон нутагтаа хэдий чинээ урт хугацаанд амьдарна төдий чинээ улс төрд оролцох боломж нэмэгдэж байгаа нь харагдлаа.

Судалгаанд нийт 631 оролцогч хамрагдсанаас 630 нь намын гишүүнчлэлийн талаар мэдээллээ өгсөн. Оролцогчдын 298 буюу 49 хувь нь МАН, 239 буюу 39.3 хувь нь АН, 2 буюу 0.3 хувь нь ХҮН, 37 буюу 6 хувь нь бусад нам, 32 буюу 5.3 хувь нь нам бус байв. Тодруулбал, Сонгуульд нэр дэвшигч_Намын гишүүн хувьсагчийн үнэлэгдсэн утга эерэг бөгөөд статистикийн ач холбогдолтой байгаа нь намын харьяаллаас хамаарч улс төрийн оролцоо шууд нэмэгдэнэ гэж дүгнэж болохоор байна. Намын гишүүнчлэлтэй оролцогчдын намдаа эзлэх байр суурийг тодорхойлоход бүх намуудын хувьд жирийн гишүүний эзлэх хувь хамгийн өндөр буюу 52.7 хувиас дээш байгаа бол намын дээд удирдлагын багийн гишүүний эзлэх хувь хамгийн бага 1.7~2.5 хувь хэлбэлзэж байна. Судалгаанд оролцогчдын 79.3 хувь нь сум, дүүргийн ИТХ-д, 16.4 хувь нь Аймаг, нийслэлийн ИТХ-д нэрээ дэвшүүлсэн байна.




ҮР ДҮН 3: Эмэгтэйчүүд орон нутгийн сонгуульд өрсөлдөх зардлыг гэр бүлийн гишүүдээс, хамаатан саднаасаа бүрдүүлдэг бөгөөд сонгуульд ялалт байгуулахад нэр хүнд, одоогийн эрхэлж буй албан тушаал ихээхэн нөлөөлдөг байна.

Судалгаанд оролцогч эмэгтэйчүүдийн дөнгөж 1.7 хувь нь 2004-2020 онд тасралтгүй буюу 6 удаа ИТХ-д өрсөлдөж, төлөөлөгчөөр сонгогдон ажиллажээ. Эмэгтэйчүүдийн 71.7 хувь нь орон нутгийн сонгуульд нэг удаа өрсөлдсөн нь эмэгтэйчүүдийн улс төрийн карьер төдийлэн амжилтгүй, тогтворгүй болохыг харуулж байна. Оролцогчид нэр дэвшихэд шаардагдах зардлыг дараах эх сурвалжаас бүрдүүлжээ. Үүнд:

- Гэр бүлийнхээ дэмжлэгээр бүрдүүлсэн, хамаатан саднаасаа зээлсэн – 46 хувь,
- Намын удирдлагууд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн – 30.3 хувь
- Бусад эх үүсвэрээс (хамаатан садан, найз нөхөд, иргэд олон нийт болон намын гишүүдийн тусламж дэмжлэгээр, өөрийн өмчийн борлуулсан орлогоор) – 0.8~8.4 хувь тус тус байв.

Улс төрийн сонгуульд нэрээ дэвшүүлэн, хүрсэн үр дүнг харахад “ялалт байгуулж байгаагүй” болон “нэг удаа ялалт байгуулсан” оролцогчдын эзлэх хувь тус бүр 37.3 хувь, харин 25.3 хувь нь “2 ба түүнээс дээш удаа ялалт байгуулсан” байна.

ИТХ-д нэр дэвшин хүрсэн үр дүн (n=630)



Сонгуульд оролцсон эмэгтэйчүүдээс ялалт болон ялагдалд нөлөөлсөн хүчин зүйлийн талаарх олон сонголттой хариулт бүхий асуумжид хариулсан хариултыг эрэмбэлж харвал:

Хүснэгт 5. Сонгуулийн ялалт болон ялагдалд хүргэсэн хүчин зүйлүүд, олон сонголттой (n=626)

Ялалтад нөлөөлсөн хүчин зүйл (n=326)	Хувь	Ялагдалд хүргэсэн хүчин зүйлүүд (n=305)	Хувь
өөрийн минь нэр хүнд	42.5	улс төрийн намын дотоод зохион байгуулалт ойлгомжгүй, зөрчилтэй байдал	34.4
эрхэлж буй ажил албан тушаал	37.4	сонгуулийн сурталчилгаанд зарцуулах хөрөнгө хүрэлцээгүй	31.6
намын зохион байгуулалт, дотоод менежмент	27.0	нам доторх эрэгтэйчүүдийн сөрөг хандлага	21.0
мөрийн хөтөлбөр	22.0	намын удирдлагын дэмжлэг сул	20.5
боловсролын түвшин өндөр	17.9	сонгуулийн тогтолцоо	19.9
иргэдийн эмэгтэйчүүдийг дэмжих хандлага	12.0	эмэгтэйчүүдийг эсэргүүцэх олон нийтийн хандлага	13.7
гадаад үзэмж, биеэ авч явах байдал	6.0	нөлөө бүхий намын гишүүн бус	9.8

Судалгааны үр дүнгээр сонгуулийн ялалтад эмэгтэйчүүдийн 42.5 хувь нь “Өөрийн минь нэр хүнд” гэсэн бол 34.4 хувь нь “Ялагдалд хүргэхэд улс төрийн намын дотоод зохион байгуулалт ойлгомжгүй, зөрчилтэй байдал нөлөөлсөн” гэжээ. Сонгуульд дахин нэрээ дэвшүүлэх төлөвлөгөөтэй эсэхийг оролцогчдоос тодруулахад дөнгөж 18 хувь нь “байгаа”, 26.2 хувь нь “тодорхой төлөвлөгөө байхгүй” бол 55.4 хувь нь “хэлж мэдэхгүй байна” гэж хариулжээ. Аль шатны сонгуульд нэр дэвшиж байснаас үл хамаараад энэ шийдвэр бараг адил байгаа нь судалгаанаас харагдсан.

Судалгааны ажлын хүрээнд сонгуульд дахин нэр дэвшихгүй гэсэн шийдвэрт нөлөөлж буй хүчин зүйлийг асуулга судалгааны үр дүнг нэгтгэн харууллаа.

Хүснэгт 6. ИТХ-ын сонгуульд дахин нэр дэвшихгүй байхад нөлөөлсөн хүчин зүйлс (n=165)

Нөлөөж буй хүчин зүйл	Аль нэг намын гишүүн	Бие даан нэр дэвшигч буюу намын харьяалалгүй
Хувь хүний түвшинд	- Сонгуульд зарцуулах төсөв мөнгө байхгүй; - Өөрийн хүслээр нэр дэвшээгүй; - Нас залуу байх эсвэл ахих тусам дэмжлэг авах боломжгүй;	Сонгуульд зарцуулах төсөв мөнгө байхгүй - Эрүүл мэндийн нөхцөл байдал

Гэр бүлийн түвшинд	- Гэр бүлийн гишүүд дэмждэггүй, ялангуяа нөхөр, хамтран амьдрагч эсэргүүцэх; - Гэр бүлийн зүгээс санхүүгийн дэмжлэг байхгүй; - Гэр бүлээрээ өөр газар шилжин суурьших; - Гэр бүлийн гишүүдийн эрүүл мэнд нөхцөл байдал нөлөөлөх;	- Гэр бүлийн гишүүдийн эсэргүүцэлтэй тулгарах; - Гэр бүлийн зүгээс санхүүгийн дэмжлэг байхгүй;
Орон нутгийн түвшинд	Иргэдийн дэмжлэг сул, хардалт их байх; Иргэд мөнгөний төлөөх сонголт хийх; Иргэдийн сонгуулийн боловсрол доогуур байх; Иргэд, олон нийтийн зүгээс гүтгэлэг, дайралтад өртөх; - Улс төрөөс хэт хараат байснаар ажлын байраа алдах эрсдэлийг бий болгох; - Намын удирдлагуудтай үзэл бодол зөрчилдөх, нэр төрд халдах, дарамт үзүүлэх;	Иргэдийн мөнгөний төлөөх сонголт, шударга бус байдлыг хөхиүлэн дэмжих хандлага түгээмэл; Иргэдийн дэмжлэг сул, гүтгэн доромжлох нь их;
	- Ажлын ачаалал ихтэй байх; - Нам дотооддоо зөрчилтэй байх; - Намд олон жил ажилласан хүнд шагнал болгож албан тушаал олгох; - Залуучуудыг дэмждэггүй; - Нэг намын гишүүд бие биеэ дэмждэггүй, өрсөлдөгчийн байр сууринаас нэр хүндийг унагаах, гэр бүлд нь сэтгэл санааны дарамтад оруулах маркетинг хийх; - Сөрөг хүчинд ялах магадлалтай тойрогт гол төлөв эрэгтэй нэр дэвшигчдийг хуваарилах;	Ажлын ачаалал ихтэй байх;
Тогтолцоо, намын түвшинд	Намын эрэгтэй гишүүдийн дэмжлэг сул; Намын удирдлагын жендэрийн талаарх ойлголт, мэдлэг хангалтгүй; Намын зүгээс санхүүгийн дэмжлэг байхгүй; - Намын дотоод зохион байгуулалт муу, нэр хүнд нь унах (нам доторх фракцуудын бодлого, үйл ажиллагаа, зөрчилдөөн газар авах).	

Эмэгтэй нэр дэвшигчдийн үзэж байгаагаар ИТХ-ын сонгуульд нэр дэвшихгүй байхад орон нутгийн болон

тогтолцоо, намын түвшний хүчин зүйл голлох нөлөө үзүүлж байгаа нь харагдлаа. Тодруулбал, иргэд, олон нийтийн зүгээс дэмжлэг муу, иргэдийн зүгээс ихээхэн гүтгэлэг, дайралтад өртөх байдал, намын удирдлага, ялангуяа эрэгтэй гишүүдийн дэмжлэг сул, хангалтгүй байгаа нь улс төрийн оролцоонд сөргөөр нөлөөлдөг байна.

Хүснэгт 7. ИТХ-ын сонгуульд дахин нэр дэвшихэд нөлөөлсөн хүчин зүйлүүд (n=113)

Нөлөөлж буй хүчин зүйлүүд	Аль нэг намын гишүүн	Бие даан нэр дэвшигч буюу намын харьяалалгүй
Хувь хүний түвшинд	Өөрийн дуу хоолойгоо иргэд, олон нийтэд идэвхтэй хүргэх; Улс төрийн туршлагатай байх; - Өөрийн итгэл үнэмшил, зорилгод хүрэх хүсэл тэмүүлэлтэй байх (бусад эмэгтэйчүүдэд үлгэр дууриалал, өөрсдийн төлөө тэмцэх чухлыг ойлгуулах үүднээс нэр дэвших);	Улс төрийн туршлагатай байх; - Өөрийн бизнес, орлоготой байх
Гэр бүлийн түвшинд	Гэр бүлийн гишүүд намын гишүүн байх; - Гэр бүл, хамаатан садны нөлөө;	Гэр бүлийн гишүүдийн дэмжлэг
Орон нутгийн түвшинд	Намын удирдлагуудаас санал тавих; Орон нутгийн иргэдийн зүгээс нэр дэвшихийг хүссэн санал ирүүлэх, итгэл хүлээлгэх; - Улс төрд орсноор ажлын байраа алдсан тул үргэлжлүүлэн хийхээс аргагүйд хүрэх; - Нам дотроо танигдах, нэр хүндтэй байх;	Орон нутгийн иргэдийн зүгээс нэр дэвшихийг хүссэн санал ирүүлэх, итгэл хүлээлгэх;
Тогтолцоо, намын түвшинд	Улс төрийн нам нь квотоор эмэгтэйчүүдийн сонгуульд нэр дэвших боломжийг олгох;	

ИТХ-ын сонгуульд дахин нэр дэвшихэд хувь хүний болон орон нутгийн түвшний хүчин зүйлс голлох нөлөөтэй байна. Тухайлбал, өөрийн дуу хоолойгоо иргэдэд идэвхтэй хүргэх, улс төрийн туршлагатай байх, орон нутгийн намын удирдлагууд болон иргэдийн зүгээс санал тавих нь эмэгтэйчүүдийг дахин нэр дэвшихэд нөлөөлсөн байна.



ҮР ДҮН 4: Эмэгтэйчүүд улс төрд олон жил байх тусам олон нийтийн зүгээс нэр хүндэд нь халдах, хэл амаар доромжлох асуудал тулгардаг байна.

Судалгаагаар олон нийтийн хандлагыг эмэгтэйчүүдийн улс төрийн үйл ажиллагаанд оролцож буй жилээс хамааруулж үзэхэд 2 жил хүртэл улс төрд идэвхтэй оролцогч эмэгтэйчүүдийг олон нийтийн зүгээс дэмжих хандлага 32.3 хувь байснаа 3-6 жил хүртэл жилийн хувьд уг хувь буурах тал ажиглагдав. Харин 6-аас дээш жил улс төрийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож буй эмэгтэйчүүдийг олон нийтийн зүгээс дэмжих байдал нэмэгдэж байв.

Улстөрч эмэгтэйчүүдийг 18-44 насны болон 55 дээш насны эмэгтэйчүүд гэж ангилж, 55 дээш насны эмэгтэйчүүдийг 45-54 насны эрэгтэйчүүд дэмждэг болох нь харагдаж байна. Харин 18-45 насны эрэгтэйчүүд 45-54 насны эмэгтэйчүүдийг илүү дэмждэг бол, 55-аас дээш насны эрэгтэйчүүд “эсэргүүцдэг” гэсэн хариултын эзлэх хувь өндөр байв. Гэхдээ улстөрч эмэгтэйчүүдийг дэмжигч болон үл дэмжигчийн хооронд эрс ялгаа, хэт өндөр зөрүүтэй байдал харагдахгүй байна.

Орон нутгийн сонгуульд өрсөлдсөн 631 эмэгтэйчүүдийн 67 хувь нь сонгуульд оролцох үед олон нийтийн зүгээс ямар нэгэн хүндрэл бэрхшээл гараагүй бол 33 хувь нь ямар нэгэн асуудалтай тулгарсан байна. Олон нийтийн зүгээс асуудалтай тулгарсан эмэгтэйчүүдийн 69.4 хувь нь нэр хүндэд нь халдах, хэл амаар доромжлох явдалтай нүүр тулж байсан. Уг асуудал тухайн эмэгтэй намын харьяалалтай эсэхээс үл хамааран гарч байгаа нь жендэрийн хэвшмэл үзэл олон нийтийн дунд өнөөг хэр нь бат бөх оршин буйг харуулж байна.

Судалгаанд оролцогчдын 23 хувь нь “намын удирдлагын түвшинд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийг дэмждэггүй гэх хандлагыг олон нийтэд төрүүлдэг” гэсэн бол 17.6 хувь нь улстөрч эмэгтэйчүүдийн биеэ авч явж буй байдал, авлига, ашиг сонирхлын зөрчил, гэр бүлийн амьдрал зэрэг сөрөг, таагүй мэдээлэл нь эмэгтэй хүнд итгэх олон нийтийн итгэлийг бууруулаад зогсохгүй, дараагийн улс төрийн карьер хийхээр төлөвлөж буй эмэгтэйчүүдэд сөргөөр нөлөөлдөг болохыг баталсан. Улс төрд оролцох үедээ олон нийтийн зүгээс тулгарсан хүндрэл бэрхшээлийг хэрхэн даван туулсан талаар тодруулбал:

- Нөхцөл байдлыг сэтгэл зүйгээрээ даван туулсан (73 хувь);
- Гэр бүлийн гишүүдийн дэмжлэгээр даван туулсан (21 хувь);
- Хөрөнгө, санхүүгээр шийдсэн (2.4 хувь);
- Хуулийн байгууллагад хандаж, шийдүүлсэн (0.9 хувь).

Олон нийтийн зүгээс тулгарсан хүндрэл бэрхшээлийг эмэгтэйчүүдийн олонх нь өөрийн сэтгэл зүйгээр даван туулсан байна.

Судалгааны үр дүнгээр сонгуульд нэр дэвшсэн

эмэгтэйчүүд олонх нь өөрсдийн давуу талыг шударга, тууштай, нямбай, хүлээцтэй болон аливаа зүйлийг чин сэтгэлээсээ чанартай гүйцэтгэдэг гэж тодорхойлсон. Харин сул талаа санхүүгийн чадавх сул, улс төрийн амбиц бага, өөрийгөө олон нийтэд сурталчлахдаа тааруу гэж тодорхойлсон. Судалгаанд оролцогчдын 21.9 хувь нь сонгогчдын жендэрийн талаарх ойлголт, мэдлэг сул, 15.7 хувь нь сонгогчдын боловсрол хангалтгүй, 15.7 хувь нь улс төрд эрэгтэй хүн л чадварлаг байдаг гэдэгт итгэдэг, 11.7 хувь нь эрэгтэйчүүдээс хамааралтай байдалтай гэж хардаг гэсэн хүчин зүйлүүд эмэгтэйчүүдийн улс төрийн карьерт ихээхэн сөрөг нөлөө үзүүлдэг гэж хариулсан.



ҮР ДҮН 5: Нэр дэвшигч эмэгтэйчүүдийн хүний эрх, жендэрийн талаарх ойлголт мэдлэг хангалтгүй байна.

Судалгааны үр дүнгээс үзэхэд судалгаанд хамрагдсан нийт нэр дэвшигч эмэгтэйчүүдийн 20.8 хувь буюу 4 эмэгтэй тутмын нэг нь хүний эрх, эрхийн зөрчлийн талаар, 32.7 хувь буюу 3 эмэгтэй тутмын нэг нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн талаар ойлголт мэдлэг бага гэж үнэлжээ. Энэ нь эмэгтэйчүүдийн хүний эрх, эрхийн зөрчил, жендэрийн талаарх ойлголт мэдлэг хангалтгүй болохыг харуулж байгаа бөгөөд цаашид орон нутгийн сонгуульд нэр дэвшигч эмэгтэйчүүдэд хүний эрх, жендэрийн талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Хүний эрх, жендэрийн талаарх ойлголт, мэдлэгтэй байх нь өөрийн болон бусдын эрхийг хамгаалах, жендэрийн эрх тэгш байдлыг хангах, нийгмийн асуудлын үндэс суурь болсон жендэрийн хэвшмэл үзлийг халах, улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёл болон гэр бүлийн харилцаанд бат бөх оршин буй жендэрийн ялгаварлан гадуурхалтыг арилгахад ихээхэн чухал юм.

Судалгаанд оролцогч эмэгтэйчүүдийн 40 хувь буюу 5 эмэгтэй тутмын хоёр нь эрх зөрчигдсөн тохиолдолд хаана, хэнд хандаж, хэрхэн даван туулахаа мэдэхгүй гэж хариулжээ. Орон нутгийн сонгуульд эмэгтэй нэр дэвшигчдийн нэр хүндэд халдах асуудал гардаг бөгөөд тухайн нөхцөл байдлаа өөрөө л даван туулдаг байна.



ҮР ДҮН 6: Нэр дэвшигч эмэгтэйчүүд гол төлөв нийгмийн сүлжээнд нэр төрийг гутаах, гүтгүүлэх, хэл амаар доромжлуулах асуудалд илүү өртдөг ба уг асуудлаар холбогдох төрийн байгууллагад хандах нь сул байна.

Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн 2021 оны мэдээллээс үзэхэд Монгол Улсын Захиргааны хэргийн анхан шатны шүүхээр 2016 онд 184, 2020 онд 48 тус тус сонгуулийн маргааныг шийдвэрлэсэн нь 2020 оныг 2016 онтой харьцуулахад 4 дахин буурсан үзүүлэлттэй байгаа нь КОВИД-19 цар тахал нөлөөлсөн байх талтай. Байршлаар нь судлан үзвэл 2016 онд нийслэлд 38 маргаан, аймгуудын хувьд Дорнод, Дархан-Уул аймаг хамгийн их буюу 19-20 маргааныг шийдвэрлэсэн байв. Харин 2020 онд нийслэлд 3 маргаан бол Сүхбаатар, Увс аймагт 5-7 маргааныг хамгийн ихдээ шийдвэрлэжээ⁷. ЦЕГ-ын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны мэдээллээр Улсын Их Хурлын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуультай холбоотой 630 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 78 буюу 13.2 хувь нь нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд тараасан гэх гомдол мэдээлэл бүртгэгдсэн бол 2020 онд энэ төрлийн хэрэг Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн түвшинд нийт 181 гомдол хүлээн авснаас 56 буюу 30.9 хувь нь эзэлж байв.

Нэр дэвшигчийг нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон, худал мэдээллийг нийтэд тараасан, бие махбод, нэр хүнд алдар нэрд халдсан гомдлыг хүйсээр нь харах боломжгүй байгааг цаашид анхаарах шаардлагатай.

Судалгаанд хамрагдсан нийт 631 эмэгтэйн 33.3 хувь нь ямар нэгэн зөрчил гараагүй бол 66.7 хувь нь эрх зөрчигдсөн болохыг баталсан. Сонгуулийн үйл явцад эрх нь зөрчигдсөн 421 эмэгтэйд уг зөрчлүүд хаана үйлдэгдэж буйг тодруулахад 75.9 хувь нь бусад газарт (намын байр, гэр бүлийн орчин, гудамж), 28.5 хувь нь нийгмийн сүлжээнд, 8.7 хувь нь сонгуулийн сурталчилгааны байранд үйлдэгджээ.


Нийгмийн сүлжээнд нэр төрийг гутаах, гүтгүүлэх, хэл амаар доромжлох, заналхийлэл, халдлага, бусад зүй бус үйлдэлд өртөх, хийж буй үйлдлийг заах, мөшгих, хувийн амьдралыг үл хүндэтгэх, халдах зөрчлүүд хамгийн ихээр гардаг байна. Сонгуулийн сурталчилгааны байранд гарсан зөрчлүүдийн 12.0~16.7 хувь нь заналхийлэл, халдлага, үл хүндэтгэх зөрчлүүд гарч байхад, харин намын байранд гарсан бэлгийн дарамтад өртөх зөрчил нь бусад газарт гарсан зөрчлийн 44.4 хувийг эзэлж байв...

Эрх нь зөрчигдсөн гэж үзэж буй эмэгтэйчүүдийн 62.1 хувь нь гомдол гаргаагүй, 24.6 хувь нь намын удирдлагад хандсан, 13.3 хувь нь цагдаагийн байгууллагад хандсан байна. Цагдаагийн байгууллагад хандсан 56 эмэгтэйн 3 нь шүүхээр асуудлаа шийдвэрлүүлсэн. ХЭҮК-т хандсан

орон нутгийн сонгуультай холбоотой зөрчлийн тоо нийт зөрчлийн дөнгөж 1.3 хувийг эзэлж байна. Орон нутгийн сонгуулийн үйл явцад улстөрч эмэгтэйчүүдийн эрх ихээр зөрчигдөж байгаа ч гомдол гаргахгүй эсвэл өргөдлөө буцаахад хүргэдэг хэд хэдэн шалтгааныг дурдсан. Үүнд: мэдлэг ойлголт хангалтгүй, хандсан ч шийдвэрлэгдэх үйл явц удаашралтай, зардал чирэгдэлтэй, төрийн байгууллагын хүнд суртал их гэх мэт.

Зөрчил гарсантай холбоотой улстөрч эмэгтэйчүүдэд дараах сөрөг үр дагаврууд гарчээ. Тухайлбал,

Зөрчлөөс үүдэлтэй сөрөг үр дагавар (n=421), хувиар



Судалгааны үр дүнгээр зөрчлөөс үүдэлтэй эмэгтэйчүүд стресс, бухимдал нэмэгдэх, итгэлцэл буурах, гэр бүлийн зөрчил маргаан үүсэх, хүмүүстэй аль болох харилцахаас татгалзах, улс төрийн карьераа дуусгах зэрэг олон асуудал үүссэн. Дээр дурдсан сөрөг үр дагаврууд нь зөвхөн эмэгтэйчүүдэд бус нөхөр, хамтран амьдрагч, үр хүүхдүүд, ажлын хамтрагч нарт давхар нөлөөлдөг аж.

Хүснэгт 8. Эмэгтэйчүүдийн эрхийн зөрчилд нөлөөлөх хүчин зүйлүүд, хувиар /n=421/

Хүчин зүйлс	F хязгаарын утга	P критик утга ⁸	Статистикийн хувьд ялгаатай эсэх
Сонгогчдын улс төрийн боловсрол сул	3.659	0.006	p<.01
Иргэдийн хүний эрхийн талаарх ойлголт тааруу	3.214	0.013	p<.05
Хүний эрхийг хамгаалахад чиглэсэн эрх зүйн орчин хангалтгүй	3.276	0.012	p<.05
Салсан, бэлэвсэн эсвэл ганц бие	3.214	0.013	p<.05
Гэр бүлийн санхүүгийн чадавч сул	2.544	0.039	p<.05
Сонгогчдын жендэрийн хэвшмэл үзэлтэй байх	2.566	0.038	p<.05

7 Шүүхийн ерөнхий зөвлөл. Албан бичигт хариу хүргүүлэх тухай, 2021/11/01. Улаанбаатар хот.

8 Тайлбар: *** p<.01, ** p<.05, * p<.1

Судалгаагаар эмэгтэйчүүдийн эрхийн зөрчилд ямар хүчин зүйл нөлөөтэй болохыг судлахад 36.5 хувь нь сонгогчдын улс төрийн боловсрол сул, 32.7 хувь нь хүний эрхийг хамгаалахад чиглэсэн эрх зүйн орчин хангалтгүй, 32.1 хувь нь иргэдийн хүний эрхийн талаарх ойлголт мэдлэг тааруу болохыг баталсан⁹.

Судалгаанд оролцогчийн үзэл бодлоор шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжихэд дараах асуудлыг шийдвэрлэх нэн шаардлагатай байна. Үүнд:

- Олон нийтийн хүний эрх, жендэрийн талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх;
- Сонгогчдын боловсролыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд жендэрийн хэвшмэл үзлийн талаар тодорхой арга хэмжээ зохион байгуулах;
- Намуудын удирдлагын зүгээс Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх хүсэл зоригтой байх;
- Улс төрийн намууд шинэ залуу гишүүдийг дэмжих, чадавхжуулах чиглэлээр олон талт хөтөлбөрийг хэрэгжүүлэх;
- Улс төрийн намуудын хамтран эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах;
- Улс төрийн намуудын квотод тавьж буй шалгуур үзүүлэлтүүдийг эргэн харах, санхүүгийн боломжгүй эмэгтэйчүүдэд дэмжлэг үзүүлэх;
- Эмэгтэйчүүдийн улс төрийн манлайллыг нэмэгдүүлэх чиглэлээр чадавх бэхжүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх;
- Сонгуулийн тогтолцоог эргэн харах, оновчтой тэгш оролцоог хангасан тогтолцоог яаралтай хэрэгжүүлэх.

1 ДҮГНЭЛТ

Тайланд дурдагдсан гол үр дүнгүүдийг судалгааны ерөнхий зорилтын дагуу дүгнэн авч үзвэл:



ЗОРИЛТ 1. Нэр дэвшигч эмэгтэйчүүдийн улс төрийн амьдралын туршлага, оролцоо

⁹ Сонгуулийн үйл явцад эмэгтэйчүүдийн эрхийн зөрчилд сонгогчдын улс төрийн боловсрол сул ($p=.006$, $p<.01$) байдал хүчтэй нөлөөлдөг байна. Харин иргэдийн ойлголт, мэдлэг тааруу ($p=.013$, $p<.05$), эрх зүйн орчин хангалтгүй ($p=.012$, $p<.05$), гэр бүлийн хувьд салсан, бэлэвсэн эсвэл ганц бие ($p=.013$, $p<.05$), санхүүгийн чадавх сул ($p=.039$, $p<.05$), иргэдийн хэвшмэл үзэл ($p=.038$, $p<.05$) зэрэг нь тодорхой хэмжээнд нөлөөлдөг болохыг судалгаагаар тогтоогдов.

- Судалгаанд хамрагдсан нийт оролцогчдын 88.3 хувь нь МАН болон АН-ын гишүүнчлэлтэй бөгөөд тэдний 76 орчим хувь нь жирийн гишүүн байв. Улс төрийн үйл ажиллагаанд 3 эмэгтэй тутмын нэг нь 11 жилээс дээш идэвхтэй оролцож байгаагаас үзэхэд эмэгтэйчүүд улс төрийн туршлагатай болохыг батлан харуулж байна.
- Судалгаанд оролцогч нөлөө бүхий намын гишүүдийн 40 орчим хувь нь нам дотроо 20-40 хувийн квотыг тогтоон эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлж буйг хүлээн зөвшөөрсөн. Гэвч бусад намуудын тухайд квот тогтоох ажил хэрэгжихгүй байгаа нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Улс төрийн намын тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байгааг илтгэнэ. Хэдийгээр нөлөө бүхий улс төрийн намууд квот тогтоон тодорхой шалгуур үзүүлэлтүүдээр эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэхийг хичээж байгаа ч шинээр орж буй эмэгтэйчүүдэд боломж харагдахгүй байна.
- Аймаг, нийслэлийн ИТХ-д эмэгтэйчүүдийн өрсөлдөх боломж бага, харин сум, дүүргийн ИТХ-д боломж их байгаа нь судалгааны үр дүнгээс харагдсан. ИТХ-ын сонгуульд ялалт байгуулсан нийт эмэгтэйчүүдийн 71.7 хувь нь нэг удаа, харин 13.5 хувь нь 2 удаа сонгогдсон байгаа нь эмэгтэйчүүдийн улс төрийн карьер төдийлэн амжилтгүй, тогтворгүй байна. Эмэгтэйчүүд сонгуульд нэг удаа нэр дэвшээд дахин нэр дэвших талаар бодохгүй байгаа нь улс төрийн намын дотоод зохион байгуулалт байхгүй, намын удирдлагын дэмжлэг сул, сонгуульд зарцуулах мөнгөгүй, нам доторх эрэгтэйчүүдийн сөрөг хандлага, олон нийтийн гүтгэлэг, хардалт, дайралт зэрэг хүчин зүйлээс шалтгаалдаг байна.
- Орон нутгийн сонгуульд эмэгтэйчүүдийн оролцоход тэдний нас залуу байх, гэрлэлтийн баталгаатай, намын гишүүнчлэлтэй, төрийн байгууллагад ажилладаг, тухайн амьдарч буй орон нутагтаа тогтвор суурьшилтай 8-аас дээш жил амьдарсан зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна.
- Олон нийтийн зүгээс эмэгтэйчүүдийг улс төрийн үйл ажиллагаанд идэвхтэй орж ажиллахад анхны жилүүдэд дэмжиж байгаад 3 дахь жилээс дэмжихгүй, үл тоох хандлагыг гаргадаг байна. Асуулга судалгаагаар эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог 18-44 нас болон 55 дээш насны эмэгтэйчүүд, 45-55 насны эрэгтэйчүүд илүү дэмждэг байна.



ЗОРИЛТ 2. Нэр дэвшигч эмэгтэйчүүдийн хүний эрх ба жендэрийн талаарх ойлголт, мэдлэг

- Улс төрийн үйл ажиллагаанд оролцож буй эмэгтэйчүүдийн хүний эрхийн зөрчил, жендэрийн талаарх мэдлэг, ойлголт сул, эрх нь зөрчигдсөн тохиолдолд хаана, хэнд хандахаа мэдэхгүй байгаа нь судалгаагаар тогтоогдсон.



ЗОРИЛТ 3. Сонгуулийн явцад нэр дэвшигч эмэгтэйчүүдэд тулгарсан хүний эрхийн зөрчил, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн.

- Сонгуулийн явцад олон нийтийн зүгээс нэр хүндэд нь халдах, хэл амаар доромжлох, хардах, гүтгэх асуудалтай тулгарч байсан ба тухайн нөхцөл байдлыг сэтгэл зүйгээрээ даван туулсан байв. Хүндрэл, бэрхшээлтэй тулгарсан нийт 421 оролцогчдын 62.1 хувь нь гомдол гаргаагүй, дөнгөж 3 эмэгтэй л шүүхийн байгууллагад хандаж асуудлаа шийдвэрлүүлсэн байна. Эндээс үзэхэд санхүүгийн нөхцөл байдал сул, олон нийтийн жендэрийн талаарх ойлголт мэдлэг тааруу, сонгогчдын боловсрол доогуур, жендэр, эмэгтэй хүний талаарх хэвшмэл үзэл нь эмэгтэйчүүдийн эрхийн зөрчилд мэдэгдэхүйц нөлөө үзүүлж буй нь шинжилгээгээр тогтоогдсон.
- Судалгааны үр дүнгээс харахад 11-ээс дээш жил улс төрийн амьдралд идэвхтэй оролцож буй эмэгтэйчүүдэд үзэл бодлоо илэрхийлэх эрх, нэр төр, алдар хүндэд нь халдахгүй байх, төрийг удирдах хэрэгт оролцох эрх ихээр зөрчигдсөн бөгөөд эдгээр зөрчлийг гол төлөв эрэгтэй сонгогч, хамтран нэр дэвшигчдийн зүгээс үйлдсэн байна. Бэлгийн дарамтад өртсөн эмэгтэйчүүдтэй холбоотой зөрчилд 50-иас дээш хувийг намын удирдлагын зүгээс үйлдсэн байна.

| САНАЛ

Судалгааны үр дүнд суурилан дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

- Улс төрийн намуудад, ялангуяа шинээр байгуулагдсан намуудын удирдлагын түвшинд эмэгтэйчүүдэд зориулсан 20-40 хувийн квот тогтоох чиглэлээр уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах;
- Квотын дагуу эмэгтэйчүүдэд тавигдах улс төрийн намуудын шалгуур, үзүүлэлтийг эргэн харахад чиглэсэн зөвлөмжийг хүргүүлэх;
- Аймаг, нийслэлийн ИТХ-ын сонгуульд нэр

дэвших квотыг нэмэгдүүлэх, эмэгтэйчүүдийг татан оролцуулах;

- Сонгогчдын боловсролыг дээшлүүлэх чиглэлээр олон нийтэд зориулан хүний эрх, эрхийн зөрчил, жендэрийн талаар шторк, мэдээллийн хуудас, нэвтрүүлгийг бэлтгэн мэдээллийн олон талт эх сурвалжаар дамжуулан хүргэх;
- Улс төрийн үйл ажиллагаанд оролцож буй эмэгтэйчүүдийн хүний эрх, эрхийн зөрчил, жендэрийн талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор тэдний хэрэгцээ, онцлогт тохирсон сургалтуудыг танхим болон цахимаар зохион байгуулах;
- Улс төрийн намуудын үйл ажиллагаанд жендэрийн аудит хийх санал, санаачилгыг гаргах, хэрэгжүүлэх;
- Улс төрийн үйл ажиллагаанд эрх нь зөрчигдсөн тохиолдолд хаана, хэнд хандах талаар мэдээллийг агуулсан товхимол гарган нэр дэвшигч эмэгтэйчүүдэд хүргүүлэх.

| АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- УИХ. (2020, 01 30). Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. Аймаг, Нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail?lawid=15125>
- УИХ. (2020, 05 13). Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. Retrieved from "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай: <https://legalinfo.mn/mn/detail/15406>
- ЖҮХ. (2020). Монгол Улс: Жендэрийн тэгш байдлын өнөөгийн түвшин. Улаанбаатар.
- ҮСХ. (2021, 08 10). Монгол Улсын статистикийн эмхэтгэл-2020. Улаанбаатар, Монгол.
- ХЭҮК. (2021, 10 15). 2012, 2016, 2020 оны ээлжит Улсын Их Хурал болон Орон нутгийн сонгуульд нэр дэвшигчдийн жендэрийн тэгш байдлын мэдээллийн танилцуулга. Улаанбаатар хот, Монгол.
- Шүүхийн ерөнхий зөвлөл. (2021, 11 01). Хариу хүргүүлэх тухай. Улаанбаатар, Монгол.
- IPU. (2021). Inter-Parliamentary Union. Retrieved from Woman in parliament in 2021: <https://www.ipu.org/our-impact/gender-equality>

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН 2021 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН ҮЙЛ ЯВЦАД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Эх сурвалж: Монгол Улсын Хүний
эрхийн Үндэсний Комисс



Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит найм дахь удаагийн сонгуулийг 2021 оны 06 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулж КОВИД-19 цар тахлын үед тохиосон, Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн¹ хүрээнд явуулснаараа онцлог байлаа. Товлосон хугацаанд Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийг зохион байгуулсан нь хүний эрхийн хувьд эерэг үзүүлэлт юм. Ялангуяа, энэ удаагийн сонгуульд КОВИД-19-ийн улмаас тусгаарлагдсан, хэвтэн эмчлүүлж байгаа болон эмч, эрүүл мэндийн ажилтан, цагдаа, онцгой байдлын зэрэг албан хаагчид болон гадаад улсад байгаа сонгогчид саналаа өгөх боломжтой байсан нь УИХ-ын 2020 оны ээлжит сонгуулийн

дараа гарсан ахиц дэвшил юм.²

КОВИД-19 цар тахлын үед сонгогчид халдвар авахаас эмээх, хөл хорио, тусгаарлалтад байх зэрэг шалтгаанаар сонгуулийн ирц буурах магадлалтай ч 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуульд 1,210,628 сонгогч оролцсон нь нийт сонгогчдын 59.3 хувь байгаа нь урьд өмнөх сонгуулийн ирцээс буурсан үзүүлэлттэй байна.³ Уг сонгуульд аймаг, нийслэлийн 22, сум дүүргийн 339 сонгуулийн хороо, гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажлыг зохион байгуулах төв комисс болон 44 салбар комисс, 2,087 хэсгийн хороо байгуулж, тэдгээрт 42,211 эмч,

цагдаа, онцгой байдал, бусад төрийн албан хаагчид ажилласан юм.⁴

ХЭҮК Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн үеэр хөгжлийн бэрхшээлтэй, зөрчлийн улмаас баривчлагдсан болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу баривчлагдсан, цагдан хоригдсон, хугацаат цэргийн албан хаагчид, коронавируст халдварын улмаас хэвтэн эмчлүүлж байгаа, гэрээр тусгаарлагдсан, ажиглалтад байгаа сонгогчдын сонгох эрхээ эдэлж байгаа эсэхэд мониторинг хийлээ.⁵ Харьяалах хэсгийн хороодын байршил, цаг хугацааны хомс байдал, санхүү, хүний нөөц дутмаг байдлаас үндсэн оршин суух газраас өөр газар цагдан хоригдсон, баривчлагдсан сонгогчийн саналыг зөөврийн битүүмжилсэн хайрцгаар авахгүй байх тохиолдол гарч байв. Мөн коронавируст халдварын улмаас

1 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Монгол Улсын Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Ерөнхийлөгчөөр дөчин таван нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уугуул иргэнийг дөрвөн жилийн хугацаагаар сонгоно" гэж заасныг "Ерөнхийлөгчөөр тавин нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уугуул иргэнийг зургаан жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно" гэж өөрчлөн найруулж, мөн хуулийн Гучин нэгдүгээр зүйлийн 7 дахь хэсгийн "Ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа улируулан сонгож болно" гэснийг хүчингүй болгосон.

2 Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн талаар Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэлд тусгасан. Уг илтгэлийн 131-134 дэх хуудаснаас үзнэ үү.

3 2013 оны 06 дугаар сарын 26-ны өдөр болсон Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуульд 1,239,784 сонгогч оролцсон нь нийт сонгогчдын 66.5 хувь, мөн 2017 оны 06 дугаар сарын 26-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуульд 1,357,788 сонгогч саналаа өгсөн нь 68.27 хувь бөгөөд нэр дэвшигчдийн хэн нь ч саналаа өгсөн нийт сонгогчийн олонхын санал аваагүй тул хоёр дахь санал хураалтыг 2017 оны 07 дугаар сарын 07-ны өдөр явуулж, нийт сонгогчдын 60.67 хувь буюу 1,207,787 иргэн саналаа өгч, сонгуульд оролцсон байна.

4 Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн дүнгийн тухай Сонгуулийн ерөнхий хорооны илтгэл, <https://www.gec.gov.mn/blog/3218>

5 ХЭҮК 4 дүүргийн 40, 18 аймгийн 80, нийт 120 санал авах байрны бэлтгэл, зохион байгуулалттай танилцаж, ШШГЕГ-ын харьяа Цагдан хорих 18 байр, Цагдаагийн газрын харьяа Эрүүлжүүлэх, баривчлах 18 байр, Зэвсэгт хүчний болон Хилийн цэргийн 28 анги байгууллага, нийт 64 объектод мониторинг хийсэн.



эмчлүүлж байгаа, тусгаарлалт, ажиглалтад байгаа сонгуулийн эрх бүхий иргэдийн саналыг авах мөн тусгаарлах байр, эмнэлэгт ажиллаж байгаа эмч, эрүүл мэндийн ажилтан, цагдаа, онцгой байдал зэрэг албан хаагчдын саналыг авахдаа үндсэн оршин суух хаягийн харьяаллын дагуу хэсгийн хорооноос ирж зөөврийн хайрцгаар авч байсан нь тухайн газарт хүмүүсийн бөөгнөрөл бий болгож, халдвар тархах эрсдэл нэмэгдүүлж байлаа.

КОВИД-19 цар тахлын үед сонгогч хоорондын зайг баримтлан санал авах ажиллагааг зохион байгуулсан хэдий ч санал авах байрны орц, гарц нь харилцан адилгүй, зай талбай нь стандартад нийцээгүй, сургууль, цэцэрлэг, соёлын төв, сум, дүүргийн хороодын байранд байрлах нь нийтлэг, зарим байр газар доорх давхарт буюу хоёроос дээш давхарт байрлаж, цэцэрлэг, сургуулийн суралцагчдын жижиг ширээг сонгогчдын бүхээгээр ашиглаж байсан нь хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдод тохиромжгүй байв. Санал авах байр хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдод саадгүй, саналаа чөлөөтэй өгөх боломжоор хангагдсан байх нь сонгуулийн ирцийг нэмэгдүүлэх, хүний эрхийг хангахад чухал юм. Сонгуулийн

сурталчилгааны уулзалт, цуглаан нь хоёр цагаас хэтрэхгүй, халдвараас хамгаалах дэглэм сахих ёстой ч иргэд олноор хүрэлцэн ирсэн үед журам үндсэндээ мөрдөгдөхгүй байлаа.⁶

Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгааныхугацааг 15 хоноогоор тогтоосон нь олон нийтэд төдийлөн танигдаж чадаагүй нэр дэвшигчид тэгш боломж олгохгүй байж

6 Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 152 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн үед коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх түр журам"-ын 3.6 дахь хэсэг.

болзошгүй юм. Гадаад улсад сурч, ажиллаж, амьдарч байгаа сонгогчид сонгуульд оролцох боломжийг бүрдүүлсэн нь сайшаалтай ч зөвхөн ЭСЯ, консулын газар биечлэн очиж санал өгөхөөр зохицуулсан нь хүртээмжийг бууруулж байна. Сонгуулийн нэг тойрог болж, зохион байгуулагддаг онцлогтой Ерөнхийлөгчийн сонгуульд цаашид манай улс иргэдийг цахимаар оролцох нөхцөлийг бүрдүүлэх нь төрийн үйл хэрэгт оролцох эрхийг хангах дэвшилт болох юм.

Товлосон хугацаанд Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийг зохион байгуулсан нь хүний эрхийн хувьд эерэг үзүүлэлт юм. Ялангуяа, энэ удаагийн сонгуульд КОВИД-19-ийн улмаас тусгаарлагдсан, хэвтэн эмчлүүлж байгаа болон эмч, эрүүл мэндийн ажилтан, цагдаа, онцгой байдлын зэрэг албан хаагчид болон гадаад улсад байгаа сонгогчид саналаа өгөх боломжтой байсан нь УИХ-ын 2020 оны ээлжит сонгуулийн дараа гарсан ахиц дэвшил юм.



ДҮГНЭЛТ.

КОВИД-19 цар тахал бол Монгол Улсын орчин цагийн түүхэнд анх удаа тохиолдсон, дэлхийг хамарсан эрүүл мэндийн гамшигт байдал юм. БНХАУ-д гарсан үл мэдэгдэх, уушгиныхурцүрэвсэлтөвчинньшинэ төрлийн коронавирусууд үүсгэгдсэн болохыг ДЭМБ 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдөр зарласнаас

**ЦАР ТАХЛЫН ЖИЛҮҮДЭД
УИХ-ЫН БОЛОН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬ,
НӨХӨН БОЛОН ДАХИН
СОНГУУЛИУДЫГ ЯВУУЛЖ,
ТӨРИЙН ҮЙЛ ХЭРЭГТ
ОРОЛЦОХ МОНГОЛ
УЛСЫН ИРГЭНИЙ ЭРХИЙГ
САХИН БИЕЛҮҮЛЖЭЭ.**

хойш SARS-CoV-2 вирусын геномын дараалал, халдварлах байдлыг хариу арга хэмжээг оновчтой төлөвлөх түвшинд танин мэдэхэд хүн төрөлхтөн наад зах нь арван сарын хугацаа зарцуулсан билээ...⁷

Коронавируст халдварыг нутаг дэвсгэртээ тархаахгүй байх зорилгоор авсан өргөн хүрээтэй хяналт, хязгаарлалтын арга хэмжээ, дархлаажуулалтыг шуурхай явуулсны үр дүнд иргэдийнхээ амь насыг хамгаалах үүргээ Монгол Улс харьцангуй амжилттай биелүүлж байна. Монгол Улс дотоодод халдвар тархахыг 2020 оны 11 дүгээр


сар хүртэл хязгаарлаж, вирусн тархалтыг 2021 оны 05 дугаар сарыг дуустал хянаж чаджээ...⁸

Цар тахлын жилүүдэд УИХ-ын болон Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль, нөхөн болон дахин сонгуулиудыг явуулж, төрийн үйл хэрэгт оролцох Монгол Улсын иргэний эрхийг сахин биелүүлсэн байна...⁹

8 ДЭМБ-аас улс орнуудад халдвар тархсан байдлыг бүх нийтийн (community transmission), хэсэгчилсэн (clusters of cases), тохиолдлын (sporadic), халдваргүй (no cases) гэж ангилж байгаа бөгөөд Монгол Улсад 2021 оны 06 дугаар сарыг хүртэл бүх нийтийн халдвар тархаагүй байсан юм.

7 Скот Готтлиб, 'Хяналтгүй Тархалт: Яагаад бид КОВИД-19-т ялагдав, хэрхэн дараагийн цар тахлыг даван туулах вэ?' (Харпер Коллинс хэвлэлийн газар, 2021) [Scott Gottlieb, 'Uncontrolled Spread: Why COVID-19 Crushed Us and How We Can Defeat the Next Pandemic' (HarperCollins, 2021)] КОВИД-19 цар тахалтай тэмцэж байгаа АНУ-ын туршлагын талаарх уг номонд SARS-CoV-2 вирус гадаргуугаар халдварладаггүй болохыг цар тахал гарснаас хойш хэдэн сарын дараа дэлхий нийт мэдэж, АНУ хариу арга хэмжээнийхээ зааврыг жилийн дараа өөрчилсөн болохыг дурджээ.


9 УИХ-аас 2020, 2021 онд Шүүхийн тухай хууль, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль (шинэчилсэн найруулга), Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль (шинэчилсэн найруулга), Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль (шинэчилсэн найруулга), Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль (шинэчилсэн найруулга), Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль зэрэг хуулиудыг баталсан.





МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
СОНГУУЛИЙН ИРЦ, хүйсээр

2021



Эрэгтэй Эмэгтэй

Эх үүсвэр: Сонгуулийн ерөнхий хороо
Өгөгдлийн дүрслэлийг Тунгаахуй өгөгдлийн урланд бүтээв.



06

СОНГУУЛИЙН НЭЭЛТТЭЙ ӨГӨГДӨЛ

- Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий
Хорооны нээлттэй өгөгдлийн жагсаалт

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

51

СОНГУУЛИЙН НЭЭЛТТЭЙ ӨГӨГДӨЛ

Магистр П.Алтанчимэг

Сонгуулийн Ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн ахлах референт

Технологийн эрин зуун буюу аж үйлдвэрлэлийн 4-р үед байгууллага, хувь хүний хувьд хамгийн чухал, үнэ цэнэтэй зүйл бол чанартай өгөгдөл юм. Бидний эргэн тойронд, хором бүрт өгөгдөл үүсэж байдаг. Жишээлбэл, төрийн үйлчилгээ авах, дэлгүүрт худалдан авалт хийх, ибаримт бүртгүүлэх, замын хөдөлгөөнд оролцох гэх мэтээр бид өгөгдлийг үүсгэж байдаг. Мэдээллийн технологийн хөгжлийн үр дүнд энэ өгөгдлийн тоо асар хурдтай нэмэгдэж байна. Жишээлбэл, интернэт, сошиал сүлжээ, ухаалаг утас, байршил тогтоогч, мэдрэгч төхөөрөмжүүдэд олон тооны өгөгдөл бий болж байгаа юм. Аж ахуйн нэгжүүд энэхүү их хэмжээний өгөгдөлд анализ хийж, үйл ажиллагаагаа өргөжүүлэх, сайжруулах мөн инновацлаг шинэ санаа нэвтрүүлэх зэргээр хэрэглэж байна.

Харин төрд үүсэж буй их өгөгдлийг нээлттэй өгөгдөл болгох нь эрдэм шинжилгээний ажил, судалгаа шинжилгээ, инновацыг дэмжих тулгуур болно гэдгийг улс орнууд хүлээн зөвшөөрч төрийн байгууллауд нээлттэй өгөгдөл бий болгох болсон. Үүнд, 2009 оноос АНУ (data.gov), Их Британи (data.gov.uk) болон баруун Европын орнууд нээлттэй өгөгдлийг үүсгэх, түүнийг ашиглах чиглэлээр эрчимтэй ажиллаж эхэлсэн байдаг.

“Нээлттэй өгөгдөл” гэдэг нь хэн ч хандах, ашиглах, хуваалцах боломжтой, машинд уншигддаг, ямар нэгэн бүртгэл, бичиг баримт шаардагдахгүйгээр авч, чөлөөтэй ашиглаж хэрэглэж, дахин түгээж болдог, нээлттэй лицензтэй цахим өгөгдөл юм.

Өгөгдлийг нээлттэй болгох нь хэрэглэгчдэд дүн шинжилгээ, боловсруулалт хийж, мэдээллийг төрөл бүрээр гаргаж авах боломжийг олгодог. Түүнчлэн нээлттэй өгөгдлийг хөгжүүлснээр инновацыг дэмжих, эдийн засгийн өсөлтийг хангах, шинэ ажлын байр бий болгох, төрийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог

нэмэгдүүлэх, төр-хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах, төрийн үйлчилгээг шуурхай, ил тод, хүртээмжтэй болгох, үр ашгийг нэмэгдүүлэх, шударга өрсөлдөөнийг дэмжих ач холбогдолтой¹.

Нээлттэй өгөгдөл нь дараах шалгуурыг хангасан байх шаардлагатай. Үүнд:

1. Үнэн зөв байх-Нээлттэй өгөгдлийн үнэн зөв байдлыг баталгаажуулсан байна.
2. Анхдагч байх-Нээлттэй өгөгдөл нь анхдагч эх үүсвэрээс цуглуулсан байна. Ямар нэг өөрчлөлт, нэгтгэл, боловсруулалт хийгдээгүй хамгийн нарийвчилсан анхдагч өгөгдөл байна.
3. Бүрэн байх-Хуульд өөрөөр заагаагүй бол нийтийн бүх өгөгдөл нээлттэй байна.
4. Цаг тухайд нь нийтэлдэг байх-Өгөгдлийн үнэ цэнийг хадгалах үүднээс өгөгдлийг аль болох хурдан нийтэлнэ.
5. Хандах боломжтой байх-Нээлттэй өгөгдөл нь цахим хэлбэрээр хялбар олж авах боломжтой байх.
6. Машин унших боломжтой байх-Нээлттэй өгөгдөл нь машин унших /XML, CSV, JSON, RDF, JSON гэх мэт/, боловсруулах боломжтой, бүтэцлэгдсэн өгөгдөл байна.
7. Байнгын тогтвортой байх -Өгөгдөл цахим орчинд тогтвортой, хязгааргүй хугацаагаар байршина. Өгөгдөл шинэчлэгдэж, өөрчлөгдсөн тухай мэдээллийг тухай бүр оруулна.

¹ Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Дэлхийн банкны дэмжлэгээр “Ухаалаг засаг” төсөл хэрэгжүүлж байна. www.smart.gov.mn


8. Ялгаварлалтгүй байх-Нээлттэй өгөгдөл нь хэн бүхэнд нээлттэй байна. Өгөгдөлд хандахад ямар нэг бүртгэл шаардахгүй.
9. Өмчлөлгүй байх-Өгөгдлийг аль болох өмчлөлгүй, нээлттэй форматаар нийтэлнэ.
10. Нээлттэй лицензтэй байх-Нээлттэй өгөгдөл нь зохиогчийн эрх, патент, худалдааны тэмдэг гэх мэт ямар нэгэн хязгаарлалт, ашиглалтын нөхцөлгүй "Нээлттэй лиценз"-тэй байна².

Монгол Улсын Их Хурал "Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай" хуулийг 2021 оны 12-р сард баталсан бөгөөд тус хуулиар нийтийн нээлттэй мэдээллийг нээлттэй өгөгдөл болгон гаргахаар тусгасан. Үүнд: "...Хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүйгээр, тэдгээрийн эрэлт, хэрэгцээг харгалзан эдийн засаг, бизнесийг дэмжих, судалгаа, шинжилгээний ажлыг хөгжүүлэх, мэдээллийн ил тод байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор нээлттэй, хязгаарлалттай болон хаалттай мэдээллийн хүн, хуулийн этгээд, төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийг тодорхойлох боломжгүй болгон боловсруулж, нээлттэй өгөгдөл болгож болно." гэж заажээ.

Хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газраас "Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл журам"³ болон "Нээлттэй өгөгдлийн жагсаалт"-ыг байгууллага тус бүрээр нь баталсан. Төрийн байгууллагууд Монгол Улсын Засгийн газраас баталсан жагсаалтын дагуу нээлттэй өгөгдлийг тодорхой давтамжтайгаар www.opendata.gov.mn нэгдсэн порталд байршуулж, нийтэлж эхлээд байна.

2 "ТУНГААХУЙ" өгөгдлийн урлан ТББ

3 Засгийн газрын 2022 оны 200 дугаар тогтоол



МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ НЭЭЛТТЭЙ ӨГӨГДӨЛ

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл журам болон Нээлттэй өгөгдлийн жагсаалтын дагуу Сонгуулийн ерөнхий хорооноос дараах мэдээллийг төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал www.opendata.gov.mn-д байршуулж байна. Үүнд:

- Сонгуулийн тойрог, мандатын судалгаа
- Сонгуулийн хэсгийн судалгаа
- Санал авах байрны хаяг, байршлын судалгаа
- Сонгуулийн байгууллагад ажиллах ажилтны сургалтад хамрагдсан төрийн албан хаагчийн нөөцийн талаарх мэдээлэл
- Сонгуулийн хороодын бүрэлдэхүүний судалгаа
- Мэдээллийн технологийн баг, даамлын судалгаа
- Сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвслийн судалгаа
- Нэр дэвшигчдийн баримт бичиг, судалгаа
- Ажиглагчдын судалгаа
- Сонгуулийн ирцийн мэдээлэл, судалгаа
- Санал хураалтын дүнгийн нэгтгэл
- Санал тоолох төхөөрөмж бүрээс хэвлэгдсэн санал хураалтын дүн
- Хяналтын тооллогын судалгаа
- Санал өгсөн сонгогчийн нас, хүйсийн судалгаа
- Сонгогдсон нэр дэвшигчдийн болон суудлын судалгаа
- Санал хураалтын дүн /хэсэг тус бүрээр/
- Сонгуулийн зардлын нэгдсэн тайлан

зэрэг өгөгдлийг нээлттэй өгөгдөл болгон хүргэж байна.



СОНГУУЛИЙН НЭЭЛТТЭЙ ӨГӨГДЛИЙН ХЭРЭГЛЭЭ, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛНЭ

Сонгуулийн ерөнхий хорооны Мэдээлэл, судалгаа, сургалтын төв “Нээлттэй нийгэм форум” ТББ-ын дэмжлэгтэйгээр “Тунгаахуй өгөгдлийн урлан” ХХК-тай хамтран сонгуулийн дата, нээлттэй өгөгдлийг сонгогч, судлаачдад хүргэх, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна. Талууд сонгуулийн нээлттэй өгөгдлийн эрэлт, нийлүүлэлт, стандартыг тодорхойлон нээлттэй өгөгдлийг бүрдүүлэх, нийтлэх, бүтээгдэхүүн хөгжүүлж эхлээд байна.

Жишээ: www.opendata.gov.mn нэгдсэн портал дахь сонгуулийн ирц, оролцоог хувиар илэрхийлэн бүтээсэн өгөгдлийн дүрслэл. Сонгуулийн ерөнхий хорооны Мэдээлэл, судалгаа, сургалтын төв, “Тунгаахуй” өгөгдлийн урлан/TUNGAAHUI Data Studio

СОНГУУЛИЙН НЭЭЛТТЭЙ ӨГӨГДЛИЙН ЖИШЭЭ

АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСАД ХОЛБООНЫ СОНГУУЛИЙН ХОРОО (Federal Election Commission)

<https://www.fec.gov/data/> цахим хуудсаараа нэр дэвшигчид, сонгуулийн зардлын санхүүжилт болон бусад дэлгэрэнгүй нээлттэй өгөгдлийг олон нийтэд хүргэдэг байна.

ИХ БРИТАНИ УЛСЫН СОНГУУЛИЙН ХОРОО улс төрийн нам, нэр дэвшигчийн хандив, зарцуулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг нээлттэй өгөгдлийн хэлбэрээр www.electoralcommission.org.uk/ цахим хуудсаар олон нийтэд хүргэдэг. Энэхүү нээлттэй өгөгдлийг сэтгүүлч, судлаачид болон бусад сонирхогч талууд Их Британийн улс төрийн нөхцөл байдлыг ойлгох, улс төрийн оролцогчдод хариуцлага тооцох зорилгоор өргөн ашигладаг.

КАНАД УЛСЫН СОНГУУЛИЙН ТӨВ БАЙГУУЛЛАГА нь сонгуулийн нээлттэй өгөгдлийг www.elections.ca цахим хуудсаар дамжуулан олон нийтэд нээлттэй болгосон бөгөөд сэтгүүлч, судлаачид болон бусад оролцогч талууд Канадын улс төрийн тогтолцоог ойлгох, ил тод, хариуцлагатай байдлыг дэмжих зорилгоор ашигладаг.

АВСТРАЛИЙН СОНГУУЛИЙН ХОРОО (АЕС) нь сонгогчдын ирц, улс төрийн хандив болон бусад мэдээлэл зэрэг сонгуультай холбоотой өргөн хүрээний мэдээллийг www.aec.gov.au цахим хуудсаар дамжуулан олон нийтэд нээлттэй болгож, сэтгүүлч, судлаачид

Вотер Турноут at Federal Elections and Referendums

Table showing Voter Turnout at Federal Elections and Referendums:

Year	Registration	Number of Voters	Turnout
19 August 1987 (Referendum)	4,000,000	400,000	10.0%
26 October 1987	4,000,000	400,000	10.0%
26 October 1990	4,000,000	400,000	10.0%
26 October 1993	4,000,000	400,000	10.0%
26 October 1996	4,000,000	400,000	10.0%
26 October 1999	4,000,000	400,000	10.0%
26 October 2002	4,000,000	400,000	10.0%
26 October 2005	4,000,000	400,000	10.0%
26 October 2008	4,000,000	400,000	10.0%
26 October 2011	4,000,000	400,000	10.0%
26 October 2014	4,000,000	400,000	10.0%
26 October 2017	4,000,000	400,000	10.0%

болон бусад оролцогч талууд Австралийн улс төрийн тогтолцоог ойлгох, ил тод, хариуцлагатай байдлыг дэмжих зорилгоор ашигладаг.

ШИНЭ ЗЕЛАНДЫН СОНГУУЛИЙН ХОРОО нь сонгогчдын ирц, улс төрийн хандив болон бусад мэдээлэл зэрэг сонгуультай холбоотой өргөн хүрээний мэдээллийг www.elections.nz цахим хуудсаар дамжуулан нийтэд нээлттэй болгож, сэтгүүлч, судлаачид, бусад оролцогч талууд Шинэ Зеландын улс төрийн тогтолцоог ойлгох, ил тод, хариуцлагатай байдлыг дэмжих зорилгоор ашигладаг байна.



“ХАРИУЦЛАГАТАЙ СОНГОГЧ” БЭЛТГЭХ ХӨТӨЛБӨР

- Амжилтын түүх

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

55

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ “ХАРИУЦЛАГАТАЙ СОНГОГЧ” БЭЛТГЭХ СУРГАГЧ БАГШ **У.БАТЗАЯА**:



Сонгуулийн ерөнхий хороо болон энэхүү ажлыг санаачлан хэрэгжүүлж байгаа. Та бүхнээс өгсөн удирдамж, чиглэл, арга зүйн дэмжлэг маш тодорхой ойлгомжтой, төлөвлөгөө тооцоолол сайтай байсан тул сургалтыг зохион байгуулахад сайхан байсан. Ач холбогдол өндөртэй, үнэхээр цаг үеэ олсон ажил арга хэмжээ гэж үзэж байгаа. Сонгогчийн боловсролыг нэмэгдүүлж, Үндсэн хуулиар олгогдсон сонгох эрхээ эдлэх чадварт сургахаас гадна залуу үеийн төрдөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх, нийгмийн идэвх оролцоог нь идэвхжүүлэхэд эерэг нөлөөлөл үзүүлэх ач холбогдолтой байна гэж харж байгаа. Сургалт эхлүүлэхийн өмнө бяцхан айдас байсан. Учир нь сонгуулийн тухай сэдэв нь хүмүүсийн маш болгоомжтой ханддаг асуудлын

нэг байдаг тул залуу сонгогчид сургалтын үйл ажиллагааг хэрхэн хүлээж авах бол сургалт амжилттай болж чадах болов уу гэсэн эмээх бодол төрж байсан.

Гэвч хүүхэд залуус маань олон талын мэдлэг чадвартайгаас гадна, нээлттэй, чөлөөтэй харилцааг бий болгож чаддаг болсон байна. Энэ нь бидний сургалтын үйл ажиллагааг амжилттай болохын нэг үндэс юм. Цаашид “Хариуцлагатай сонгогч” хөтөлбөрийн хүрээнд Сонгуулийн ерөнхий хороо болон төслийн багтай хамтарч ажиллахаас гадна төрийн албан хаагчийнхаа хувьд хариуцлагатай сонгогч залуу үеийг бий болгохын төлөө өөрийн хариуцсан ажил үүрэгтэйгээ хөтөлбөрийн зорилго, зорилттой уялдуулан ажиллахыг хичээх болно оо.

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ “ХАРИУЦЛАГАТАЙ СОНГОГЧ” БЭЛТГЭХ СУРГАГЧ БАГШ **Д.ЮНДЭНБАЗАР**:

Хөгжлийн хөтөлбөрөөс “Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төслийн хүрээнд Сонгуулийн ерөнхий хороотой хамтран хэрэгжүүлж буй “Хариуцлагатай сонгогч” сургалтын сургагч багшаар бэлтгэгдэн аймгийн хэмжээнд 2022 оны 10 дугаар сарын 14-15-нд ажилчин, ажилтан, оюутан залуучуудын

хүрээнд 2 өдрийн үндсэн сургалтыг, 18-19-нд Баянхонгор аймгийн Номундалай цогцолбор сургуулийн 12 дугаар ангийн “Нийгмийн ухааны гүнзгийрүүлсэн сургалттай” ангийн сурагчдад тус тус амжилттай зохион байгуулсан. Орон нутгийн сургалтыг амжилттай явуулсан тул Сонгуулийн ерөнхий хорооноос Улаанбаатар хотод 2022 оны 12 дугаар сарын 19-

20-ны өдрүүдэд “Хариуцлагатай сонгогч” сургалтад сургагч багш В.Наранчимэгийн хамт хичээл заасандаа баяртай байгаа. Сургалтыг зохион байгуулахад Сонгуулийн ерөнхий хороо, аймаг, орон нутгийн удирдлагууд, боловсрол, шинжлэх ухааны газар, сургуулиудын зүгээс дэмжин анхаарч ажилласны үр дүнд амжилттай зохион байгуулсан.

“ХАРИУЦЛАГАТАЙ СОНГОГЧ” СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ЯМАР МЭДРЭМЖ ТӨРӨВ, ХҮНДРЭЛ БАЙСАН УУ?

Бид залуучуудад хандаж чадвал тэд шинэ мэдээлэл авах, өөрийгөө хөгжүүлэхэд анхаарч байгаа нь ажиглагдсан. Сургалтын явцад тэдний оролцоог хангаж ажилласнаар залуучууд өөрийгөө нээх, хамтач байдлыг төлөвшүүлэх ач холбогдолтой байсан. Харин цаашид сонгууль өгч чаддаггүй, мэдээллээс хол байдаг малчин, уурхайчид, хилийн цэргийнхэнд сургалт, мэдээллийг түлхүү өгмөөр санагдсан.

УИХ-ын 2024 оны болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын төлөөлөгчдийн сонгуулиас өмнө тодорхой зорилтот бүлгийн сонгогч залуучуудад “Хариуцлагатай сонгогч” сургалтыг зохион байгуулах, Сонгуулийн ерөнхий хороо, Мэдээлэл, судалгаа, сургалтын төвтэй хамтран “Залуу сонгогчийн боловсролыг дээшлүүлэх” чиглэлээр хэрэгжүүлэх бодлогын бичиг баримт боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай гэсэн саналтай байгаа.

ХАРИУЦЛАГАТАЙ СОНГОГЧ” БЭЛТГЭХ ХӨТӨЛБӨР ЯМАР АЧ ХОЛБОГДОЛТОЙ ВЭ?

Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу залуу сонгогчдыг сонгох, сонгогдох эрхээ эдлэх боломжийг хангах, сонгуулийн хууль тогтоомжийг тайлбарлан таниулах, сонгогчдын боловсролыг дээшлүүлэх асуудал нь цаг үеэ олсон ажил болж байгаа. Сүүлийн жилүүдэд сонгууль өгдөггүй, сонгуулийг үл тоодог залуучуудын тоо өсөн улам бүр нэмэгдэж байгаа нь залуучуудын орон болсон манай орны хувьд анхаарах асуудлын нэг мөн. Энэхүү сургалтын үр дүнд сонгуулийн ач холбогдол, сонгуульд оролцохын чухлыг, сонгуулийн эрх болон үндсэн зарчмууд, үйл явц, мөрийн хөтөлбөр гэж юу болох, сонгуулийн сурталчилгааны хууль ёсны арга хэлбэрүүдийг хууль бус арга хэлбэрүүдээс ялгах, сонгуульд оролцогч талуудын үйл ажиллагаа, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, хяналт тавьж ажиллах, сонгуулийн үед болон дараа хариуцлагатай сонгогч байх талаар дэлгэрэнгүй ойлголттой болсноор залуучууд

сонгуульд тодорхой мэдлэгтэйгээр оролцон сонгох, сонгогдох эрхээ хуулийн хүрээнд хэрэгжүүлэх чадвартай болох боломж нээгдэх юм.

Сургалтад хамрагдсан залуучуудын хувьд сэтгэл маш өндөр байсан бөгөөд ирэх жилийн сонгуулиудад оролцох, үеийн найз нөхдөө уриалан дуудах эрмэлзэлтэйгээ илэрхийлж байсан нь дээрх сургалт цаг үеэ олсон, зайлшгүй хийж, хэрэгжүүлэх ажлын нэг байсны илэрхийлэл юм.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ “ХАРИУЦЛАГАТАЙ СОНГОГЧ” БЭЛТГЭХ СУРГАГЧ БАГШ Р.МАШБАТ:

Сургалтдаа ихээхэн ач холбогдол өгч бэлтгэсэн. Оролцогчдынхоо анхаарлыг татаж, сонирхолтой хэлбэрээр зохион байгуулахыг хичээсэн учраас суралцагч хүүхдүүд бүтэн хоёр өдрийн сургалтдаа маш идэвхтэй хамрагдсан. Миний хувьд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2016 оны ээлжит сонгуулиас эхлэн УИХ, орон нутгийн ээлжит зургаан сонгууль, нөхөн, дахин сонгуулиудад хэдэнтээ томилогдож, Аймгийн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүнээр ажилласан туршлагатай тул хичээлээ заахад дөхөмтэй байлаа.

Сонгогчдын ирц, оролцоог насаар нь ангилахад хамгийн идэвх муутай хүмүүс нь 35-аас доош насныхан байдаг. Тиймээс нэг удаа ч болов тэдэнд, оюутан залууст сонгуулийн тухай ойлголт, мэдлэг өгч, хариуцлагатай сонгогч байхад нь нөлөөлөх алхам хийсэндээ

баярласан. Монгол Улсад байнгын ажиллагаатай сонгуулийн төв байгууллага байгуулагдаад 30 жилийн хугацаа өнгөрч, Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын, орон нутгийн тус бүр 8 удаагийн сонгуулийг амжилттай зохион байгуулж, сонгууль зохион байгуулалтын хувьд үйл ажиллагаа жигдэрсэн гэж би хувьдаа дүгнэдэг. Харин одоо Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо сонгуулийг маргаангүй, хуулийн хүрээнд зохион байгуулахад анхаарахаас гадна сонгогчдын боловсролд түлхүү анхаарч эхэлж байгаа нь шинэлэг бөгөөд маш чухал алхам юм. “Хариуцлагатай сонгогч” бэлтгэх хөтөлбөр бол иргэд өөрийнхөө сонголтоор, өөрийнхөө итгэл үнэмшлээр сонголтоо хийж, эрхээ чөлөөтэй эдлэхэд мэдлэгийг олгож буй хамгийн чухал арга хэмжээ юм. Хөтөлбөрийн

хүрээнд иргэдэд сонгуулийн тухай ойлголт, ач холбогдол, сонгуульд оролцож, саналаа өгөхийн чухлыг ойлгуулж, сонгох, сонгогдох эрхээ хэрэгжүүлэх, “Таны сонголт улс орны ирэх 4 жилийн хувь заяаг шийдэх хариуцлагатай агшин” гэдгийг ойлгуулах нь л хамгийн чухал ач холбогдолтой.

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооноос бэлтгэсэн анхны сургагч багш нарын нэг болж, сертификат авсандаа баяртай байгаа. Аймгийн ЗДТГ-ын, хамт бэлтгэгдсэн сургагч багш Б.Мөнгөн-Эрдэнэтэй хамтраад аймгийн төвийн болон сумдын ЕБС-ийн ахлах ангийн сурагчид, залууст үе шаттай сургалт явуулж, сонгуулийн ирц, оролцоог нэмэгдүүлэх, иргэдийн сонгох, сонгогдох эрх чөлөөгөө эдлэхэд дэмжлэг үзүүлэх, илүү их зүйлийг зорьж, ажиллах болно.





НИЙСЛЭЛИЙН БАГАНУУР ДҮҮРЭГ ДЭХ “ХАРИУЦЛАГАТАЙ СОНГОГЧ” БЭЛТГЭХ СУРГАГЧ БАГШ Б.НАРЛАГМАА:

- Сургагч багш бидэнд Сонгуулийн ерөнхий хороо болон “Хариуцлагатай сонгогч” бэлдэх төслөөс багшлах арга зүй, төлөвлөгөө, сургалтад хэрэгцээт сурах бичиг, гарын авлага, хэрэглэгдэхүүнээр хангаж, дэмжиж, хамтарч ажилласан тул бүх зүйл тодорхой, ойлгомжтой байлаа. Тийм ч учраас бид сургалтаа төлөвлөсөн ёсоор сонирхолтой, үр дүнтэй зохион байгуулсандаа сэтгэл өег байгаа. Сонгуулийн ирц, оролцооны асуудал хөндөгдөж буй энэ цаг үед энэ төсөл цаг үеэ олсон үйл ажиллагаа юм. Сонгогчийн боловсрол маш чухал. Залуу үеийг улс төрийн эрх, эрх чөлөөгөө эдлэх, иргэний эрх, үүрэг, хариуцлагаа ухамсарлах, сонгуулийн

талаар мэдлэг, ойлголттой болгоход анхаарч байгаа нь сайн хэрэг.

Сургалтын үеэр их зүйлийг анзаарч, олж харлаа. Бидний амьдарч буй өнөөгийн нийгэм, цахим ертөнц өсвөр насны хүүхдүүдэд буруу зөрүү ойлголт өгөхүйц хортой нөлөө үзүүлж байгааг, тэдний үзэл бодлыг сонсохгүй, өмнөөс шийдвэр гаргадаг гэх мэт томчуудын анзаардаггүй асуудал олон гэдгийг мэдлээ. Сошиал орчин хүүхэд, залуусын бие, эрүүл мэндээс гадна мэдээлэл авах, хүмүүнжих, үзэл бодол төлөвших, эрхээ эдлэхэд сөргөөр нөлөөлж байгааг сургалтад оролцогч хүүхдүүд өөрсдөө хөндөн ярьж, шүүмжилж байсан юм.

Багануур дүүргийн сургагч багш нар бид энэ жил хэд хэдэн зүйл төлөвлөсөн. Юуны өмнө дүүргийнхээ Иргэдийн төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааг ахлах ангийн сурагчдад танилцуулж, ээлжит болон ээлжит бус хурлуудад иргэний хувиар оролцуулж, иргэдийн төлөөллийг сонгохын ач холбогдлыг таниулна. Цаашлаад бидний өдөр тутмын амьдралд иргэдийн төлөөлөл ямар нөлөөтэй, ямар үүрэгтэй, чухал шийдвэрийг гаргахад иргэдийн дуу хоолой хэрхэн нөлөөлдөг зэрэг хэрэгцээт мэдээллийг өгч, эрх зүйн ойлголт, мэдлэг олгоход чиглэж ажиллахаар төлөвлөж байна.





“СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛ” КЛУБ БАЙГУУЛАГДЛАА

Магистр З.Бадмаараг

Сонгуулийн ерөнхий хорооны хэвлэлийн төлөөлөгч-Референт

Сонгуулийн Ерөнхий хорооны даргын 2023 оны нэгдүгээр сарын 09-ний өдрийн А/03 захирамжаар тус Хорооны дэргэд “Сонгуулийн боловсрол” сэтгүүлч, эрдэмтэн, судлаачдын сайн дурын клубыг байгууллаа. Тус клуб нь сонгуулийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх зорилготой бөгөөд сонгуулийн хууль тогтоомж, ард нийтийн санал асуулгыг иргэдэд тайлбарлан таниулах, сонгогчдыг мэдээ, мэдээллээр хангах, сурталчлах, сонгуулийн судалгааг хөгжүүлэх, мэргэшүүлэх сургалтуудыг тогтмол зохион байгуулах, сэтгүүлч, судлаачдыг дэмжих зэргээр

иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллана.

“Сонгуулийн боловсрол” клубт одоогийн байдлаар хэвлэл мэдээллийн 29 байгууллага, сэтгүүлчдийн мэргэжлийн холбоо-2, иргэний нийгмийн байгууллага-4 бүртгүүлж, сэтгүүлч, судлаачид гишүүнээр элсэж, сар тутмын уулзалт-сургалтыг хоёр удаа явуулаад байна. Эхний уулзалтаар Сонгуулийн ерөнхий хорооноос сонгуулийн боловсролын чиглэлээр явуулж буй бодлого, үйл ажиллагааг танилцуулж, клубын журам, зохион байгуулалт, 2023 оны төлөвлөгөөг



баталсан бол хоёрдугаар сард Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2023 оны нөхөн болон дахин сонгуулийн бэлтгэл ажлын явц, эрх зүйн зохицуулалт, Сонгуулийн автоматжуулсан системын тухай хууль, “Санал авах байрны стандарт, зохион байгуулалт” сэдвээр сургалт, мэдээлэл хийлээ.

Мөн Сонгуулийн ерөнхий хорооны Ажлын албанаас Санал авах байрны жишиг загварыг байгуулснаа клубын гишүүдэд нээлттэй танилцуулж, Хорооны дэргэдэх МТТ санал тоолох төхөөрөмжийн ажиллагаатай биечлэн танилцах, сорилт, хяналт тавих боломж нөхцлийг бүрдүүлэн дадлага-сургалтыг хамтран явууллаа.

“Сонгуулийн боловсрол” клуб нь зохицуулагч, Удирдах зөвлөл, гишүүд гэсэн бүтэцтэй. Нийт гишүүдийн хүсэлтээр клуб нь Хорооны дэмжлэгтэйгээр сар тутмын мэргэшүүлэх сургалт, уулзалтыг тогтмол зохион байгуулж, “Сонгуулийн боловсрол” сошиал хуудсыг хөтлөн сонгуулийн боловсролыг түгээхээр төлөвлөөд байна.







СОНГУУЛЬ ДЭЛХИЙ ДАХИНД

- Олон улсын сонгуулийн хуанли-2023 он

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

63

ОЛОН УЛСЫН СОНГУУ



БҮГД НАЙРАМДАХ ЧЕХ

Сонгуулийн төрөл:
Ерөнхийлөгч

Огноо: 2023-01-13



ЭКВАДОР

Сонгуулийн төрөл: Ард
нийтийн санал асуулга

Огноо: 2023-02-05



НИГЕР

Сонгуулийн төрөл: Ерөнхий
- Төлөөлөгчдийн танхим,
Сенат, Ерөнхийлөгч

Огноо: 2023-02-25



ЖИБУТИ

Сонгуулийн төрөл:
Жибутийн Үндэсний
Ассамблей

Огноо: 2023-02-28



ЭСТОНИ

Сонгуулийн төрөл:
Парламент

Огноо: 2023-03-05



МИКРОНЕЗИЙН ХОЛБООНЫ УЛС

Сонгуулийн төрөл: Конгресс

Огноо: 2023-03-07



МОНТЕНЕГРО

Сонгуулийн төрөл:
Ерөнхийлөгч

Огноо: 2023-03-19



КАЗАХСТАН

Сонгуулийн төрөл:
Төлөөлөгчдийн танхим

Огноо: 2023-03-19



ТУРКМЕНИСТАН

Сонгуулийн төрөл:
Туркменистанийн Үндэсний
Ассамблей

Огноо: 2023-03-31



ГРЕНАДА

Сонгуулийн төрөл:
Төлөөлөгчдийн танхим

Огноо: 2023-03-31



КУБА

Сонгуулийн төрөл:
Үндэсний Ассамблей

Огноо: 2023-03-31



БОЛГАР

Сонгуулийн төрөл:
Үндэсний Ассамблей

Огноо: 2023-04-02

ЛИЙН ХУАНЛИ-2023



ФИНЛАНД

Сонгуулийн төрөл:
Парламент

Огноо: 2023-04-02



БУТАН

Сонгуулийн төрөл:
Үндэсний Зөвлөл

Огноо: 2023-04-30



ПАРАГВАЙ

Сонгуулийн төрөл:
Ерөнхий - Төлөөлөгчдийн
танхим, Сенатийн танхим,
Ерөнхийлөгч

Огноо: 2023-04-30



АНДОРРА

Сонгуулийн төрөл:
Ерөнхий Зөвлөл

Огноо: 2023-04-30



ТАЙЛАНД

Сонгуулийн төрөл:
Төлөөлөгчдийн танхим

Огноо: 2023-05-07



ТИМУР

Сонгуулийн төрөл:
Парламент

Огноо: 2023-05-31



ГРЕК

Сонгуулийн төрөл:
Парламент

Огноо: 2023-06-08



ТУРК

Сонгуулийн төрөл:
Ерөнхий - Үндэсний
Ассамблей, Ерөнхийлөгч

Огноо: 2023-06-18



СЬЕРРА ЛЕОН

Сонгуулийн төрөл:
Ерөнхий - Парламент,
Ерөнхийлөгч

Огноо: 2023-06-24



ГУАТАМАЛА

Сонгуулийн төрөл:
Ерөнхий - Конгресс,
Ерөнхийлөгч

Огноо: 2023-06-25



КАМБОДЖ

Сонгуулийн төрөл:
Үндэсний Ассамблей

Огноо: 2023-07-23



СУДАН

Сонгуулийн төрөл:
Ерөнхий - Үндэсний
Ассамблей, Ерөнхийлөгч

Огноо: 2023-07-31



МЬЯНМАР

Сонгуулийн төрөл:
Төлөөлөгчдийн танхим,
Үндэстний танхим

Огноо: 2023-07-31



ЗИМБАБВЕ

Сонгуулийн төрөл:
Ерөнхий - Үндэсний
Ассамблей, Ерөнхийлөгч

Огноо: 2023-07-31



ПАКИСТАН

Сонгуулийн төрөл:
Үндэсний Ассамблей

Огноо: 2023-07-31



МАЛЬДИВ

Сонгуулийн төрөл:
Ерөнхийлөгч

Огноо: 2023-09-09



СЛОВАК

Сонгуулийн төрөл:
Үндэсний Зөвлөл

Огноо: 2023-09-30



ЭСВАТИНИ

Сонгуулийн төрөл:
Танхимын Ассамблей

Огноо: 2023-09-30



МАВРИТАНИ

Сонгуулийн төрөл:
Үндэсний Ассамблей

Огноо: 2023-09-30



РУАНДА

Сонгуулийн төрөл:
Гишүүдийн танхим

Огноо: 2023-09-30



ТУВАЛУ

Сонгуулийн төрөл:
Танхимын Ассамблей

Огноо: 2023-09-30



ЛИБЕРИ

Сонгуулийн төрөл:
Ерөнхий - Төлөөлөгчдийн
танхим, Ерөнхийлөгч

Огноо: 2023-10-10



ШВЕЙЦАР

Сонгуулийн төрөл:
Мужуудын Зөвлөл

Огноо: 2023-10-23



УКРАЙН

Сонгуулийн төрөл:
Дээд Зөвлөл

Огноо: 2023-10-29



АРГЕНТИН

Сонгуулийн төрөл:
Ерөнхий - Төлөөлөгчийн
тэнхим, Сенат


Огноо: 2023-10-29



ГАБОН

Сонгуулийн төрөл:
Үндэсний Ассамблей

Огноо: 2023-10-31



ПОЛЬШ

Сонгуулийн төрөл:
Ерөнхий - Доод танхим,
Сенат

Огноо: 2023-10-31



ОМАН

Сонгуулийн төрөл:
Зөвлөлдөх Ассамблей

Огноо: 2023-10-31



ШИНЭ ЗЕЛАНД

Сонгуулийн төрөл:
Төлөөлөгчдийн танхим

Огноо: 2023-10-31



ЛЮКСЕМБУРГ

Сонгуулийн төрөл:
Гишүүдийн танхим

Огноо: 2023-10-31



БУТАН

Сонгуулийн төрөл:
Үндэсний Ассамблей

Огноо: 2023-10-31



МАРШАЛЛЫН АРЛУУД

Сонгуулийн төрөл:
Парламент

Огноо: 2023-11-20



БЕЛАРУСЬ

Сонгуулийн төрөл:
Төлөөлөгчдийн танхим

Огноо: 2023-11-30



ИСПАНИ

Сонгуулийн төрөл:
Ерөнхий - Гишүүдийн
танхим, Сенат

Огноо: 2023-12-10



КОНГО (АРДЧИЛСАН БҮГД НАЙРАМДАХ)

Сонгуулийн төрөл:
Ерөнхий - Үндэсний
Ассамблей, Ерөнхийлөгч

Огноо: 2023-12-20



БАНГЛАДЕШ

Сонгуулийн төрөл: Ерөнхий

Огноо: 2023-12-р сард



МАЛИ

Сонгуулийн төрөл:
Ард нийтийн санал асуулга

Огноо: 2023-12-р сард



ТОГО

Сонгуулийн төрөл:
Үндэсний Ассамблей

Огноо: 2023-12-31

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



**МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН
ЕРӨНХИЙ ХОРОО**

Засгийн газрын 11 дүгээр байр
Ж.Самбуугийн гудамж,
Улаанбаатар – 15141, Монгол Улс

Санал хүсэлт хүлээн авах хаяг:

gecm@gec.gov.mn
(976) -51 262127

УИХ.МН
СҮЛЭЛГ ААХ.САН